

Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл

Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХКК



Тим Штайверг, Анне Шуит

Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл

Кейс судалгаа: Монголын “Алтайн
Хүдэр” ХХК

“Үндэстэн дамнасан корпорацуудын судалгааны төв” SOMO

Тим Штайнвег, Анн Шюйт

Амстердам хот, 2014 оны 12 дугаар сар

Colofon

Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл

Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

2014 оны 12 дугаар сар

Зохиогч: Тим Штайнвег, Анн Шюйт

Хэвлэлийн эх: Франс Шупп

Хавтасны зураг: Свен Хэртиг-Токарз – “Төв болон Зүүн Европын Банкны хяналт Сүлжээ” CEE Bankwatch

ISBN: 978-94-6207-051-6

Энэхүү тайланг Нидерланд Улсын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ. Тайлангийн агуулгын хувьд SOMO дангаараа хариуцлага хүлээх бөгөөд тайланд тусгасан аливаа дүгнэлт, санаа бодол нь Нидерланд Улсын Гадаад Хэргийн Яамны байр суурь огтхон ч биш болно.

Хэвлэсэн:



Stichting Onderzoek Multinationale Ondernemingen (SOMO)

“Үндэстэн дамнасан корпорацуудын судалгааны төв”

Сарфатистраат 30

1018 GL Амстердам

Нидерланд Улс

Утас + 31 (20) 6391291

Факс + 31 (20) 6391321

info@somo.nl www.somo.nl

“Үндэстэн дамнасан корпорацуудын судалгааны төв” (SOMO) нь тогтвортой хөгжлийн нийгэм, экологи, эдийн засгийн асуудлуудын чиглэлээр судалгаа хийдэг хараат бус, ашгийн төлөө бус судалгааны болон гишүүнчлэл бүхий байгууллага юм. Энэ байгууллага 1973 оноос эхлэн үндэстэн дамнасан корпорацууд, тэдгээрийн үйл ажиллагаа дэлхийн улс орнуудын ард иргэд, байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа талаар түлхүү судалгаа хийж байна.



Агуулга

Товч хуурангуй	5
1 Оршил	9
1.1 Зорилго ба зорилтот бүлгүүд	8
1.2 Арга зүй.....	10
1.3 Хязгаарлалт.....	10
1.4 Тайлангийн бүтэц	12
2 Монгол дахь төмрийн хүдэр олборлох салбар	11
2.1 Монголын уул уурхайн салбар	12
2.2 Монгол дахь төмрийн хүдрийн олборлолт	13
2.3 Нийгмийн болон байгаль орчны нөлөөлөл	14
3 “Алтайн Хүдэр” ХХК-ийн тухай товч танилцуулга	15
3.1 Компанийн болон өмчлөлийн бүтэц.....	15
3.2 Санхүү	17
3.3 Бизнесийн стратеги	18
3.3.1 Өрсөлдөөний орчин	18
3.3.2 Өрсөлдөх чадвар	20
4 Таян нуурын уурхайн нөлөөлөл	23
4.1 Атозамын нөлөөлөл: тоосжилтоос үүдэлтэй бохирдол болон мал, хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл	23
4.2 Уурхайн нөлөөллийн бүс дэх албадан нүүлгэн шилжүүлэлт	27
4.3 Сонирхогч талуудын оролцоо хангалтгүй байна	30
5. Байгаль орчин, нийгмийн стандартуудын зөрчил	32
5.1 ГШ 1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ ба менежмент	32
5.2 ГШ 3: Бохирдлоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах	33
5.3 ГШ 5: Газар чөлөөлөх, албадан нүүлгэн шилжүүлэлт ба эдийн засгийн суурьшил алдалт . . .	33
5.4 ГШ 10: Мэдээллийн ил тод байдал ба сонирхогч талуудын оролцоо	35
6. Дүгнэлт	36
6.1 Тээвэрлэлтийн зам орон нутгийн иргэдэд сөргөөр нөлөөлж байна.	36
6.2 Ганц удаагийн бэлэн мөнгөний нөхөн олговор нь нөхөн олговрын зохистой хэлбэр болж чадахгүй байна	37
6.3 Уурхайн богино насжилт сонирхогч талуудын бодит оролцоог хангах хөшүүрэг болж чадахгүй байна	38
6.4 ЕСБХБ-ны оролцоо сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх баталгаа болж чадахгүй байна	39
Хавсралт: ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлагууд	41

Товч хураангуй

Энэхүү тайлан нь төмрийн хүдрийн салбар нийгэм, байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгааг Монголын уул уурхайн “Алтайн Хүдэр” ХХК-ийн жишээн дээр тогтоох зорилго бүхий кейс судалгаа юм. Тайланг боловсруулахад холбогдох тайлан, баримт бичгийг судалснаас гадна Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)-аас санхүүжилт авсан “Алтайн Хүдэр” ХХК-ийн олборлолт хийж байгаа Таян нуурын уурхайн ойр хавийн орон нутагт 2014 оны 8 дугаар сард очиж хийсэн мэдээлэл цуглуулах судалгааны үр дүнг ашигласан болно. Тайланд төмрийн хүдрийн салбар, мөн компанийн стратеги орон нутгийн иргэдэд үзүүлж буй сөрөг нөлөөлөлтэй хэрхэн уялдаж байгааг харуулав.

Энэхүү кейс судалгаагаар тухайн компани сонирхогч талуудын эрх, мөн нийгэм, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн зохистой арга хэмжээнүүдийн талаар холбогдох оролцогч талуудтай үр дүнтэй хэлбэрээр зөвлөлдөх, тэдгээрийн оролцоог хэрхэн хангаж чадаж байгаа нь компанийн зүгээс сайн үйлс хийх санаа санаачлага, эсвэл уг компанид хөрөнгө оруулалт хийсэн санхүүжүүлэгч байгууллагын баримталдаг тогтвортой хөгжлийн бодлогоос зөвхөн хамаардаггүй гэдгийг харуулав. Эдгээр нь дэд бүтцийн хэрэгцээ, уурхайн насжилт, үйлдвэрлэлийн зорилт зэрэг бизнесийн хүчин зүйлээс мөн адил хамаарч байна. Эдгээр бизнесийн хүчин зүйлс нь бодит, үр дүнтэй оролцооны зарчимтай зөрчилдөх тохиолдолд орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудын эрх зөрчигдөх, тэдгээрийн амьжиргаа доройтох эрсдэл бий болгох магадлалтай байна.

Гангийн үйлдвэрлэлийн гол түүхий эд болох төмрийн хүдэр нь манай орны эдийн засгийн бүх салбарт чухал үүрэгтэйн зэрэгцээ төмрийн хүдрийн зах зээлийн төлөв байдал уг зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа компанийн бизнесийн стратегид голлох нөлөөлөл үзүүлж байна. Нөгөөтэйгүүр, компанийн бизнесийн стратегиуд төмрийн хүдрийн уурхайнуудын нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж байна. Одоогийн байдлаар “Алтайн Хүдэр” компани нь Монголд төмрийн хүдэр олборлодог хоёрдахь том компани юм. Далайн тээврээр тээвэрлэсэн төмрийн хүдрийн зардал өндөр байдаг тул уг уурхай Хятадын хилд ойрхон буюу 168 км зайд ойршиж байдгаараа Хятадын Баруун хойд нутгийн гангийн үйлдвэрүүдийн сонирхолыг татдаг гол нийлүүлэгч нь юм. “Алтайн Хүдэр” компани одоогоор уурхайгаас хил хүртэл хатуу хучилттай зам тавьж байгаа ба ингэснээр тээвэрлэлтийн зардлыг 25 хувиар бууруулах боломжтой хэмээн үзэж байна. Энэ оны эхэн үеэс эхлэн төмрийн хүдрийн зах зээлийн үнэ огцом унасан тул “Алтайн Хүдэр” тодорхой хүндрэлтэй тулгараад байна. Хэдийгээр үйлдвэрлэлийн хэмжээг огцом нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа хэдийч үнэ унасан энэ нөхцөлд Таян нуурын уурхай хүчин чадлынхаа дөнгөж 30 хувьд олборлолт хийж байна.

Тээвэрлэлтийн зам орон нутгийн иргэдэд сөрөг нөлөөлөл үзүүлж байна

Төмрийн хүдэр тээвэрлэж байгаа одоогийн шороон замаас тоос их босохын зэрэгцээ дуу чимээ их гарч байна. Шороон замаас болж малын бэлчээр тоосонд дарагдах, улмаар мал амьтан өвдөх тохиолдол их гарч байгаа гэж ярилцлагад хамрагдсан малчид хэлж байв. Тоосжилтоос болсон малын өвчнөөс болж гол төлөв ямаа, тэмээ зэрэг хэдэн арван малаа алдсан гэж малчид өгүүлж байв. Үүнээс гадна малын бэлчээр дайрч гарч байгаа шинэ замын барилгын ажлын талаар хангалттай хэмжээнд ярилцаж тохироогүй хэмээн малчид үзэж байна.

Шинэ зам гарам гарцгүй баригдаж байгаа нь малчдын хувьд гол асуудал болж байна. Шинэ замын зорчих хэсэг нь харьцангуй өндөрлөгтэй тул аюулгүй гарам гарцгүйгээр мал замын Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл – Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

нөгөө талд гарч бэлчих, хүн мал өвөлжөө хаваржааны нутаг руу нүүхэд саад тотгор учруулж байна.

Уурхайн олборлолтын нөлөөлөлд өртсөн сонирхогч этгээдийн бүлэг нь уурхайн талбайн дэргэд, эсвэл түүний ойр орчим амьдардаг бүлгээс хамаагүй том байгааг эдгээр баримт харуулж байна. Дэд бүтцийг хөгжүүлэх нь ойр орчим амьдардаг иргэдэд үр өгөөжтэй хэмээн олонтаа хэлж ярьдаг. Гэсэн хэдийч шинээр барьсан зам харгүй нь одоо ашиглаж байгаа бэлчээрийн газрыг хуваах, мөн өсөн нэмэгдсэн замын хөдөлгөөн нь уурхайн талбайгаас хол амьдардаг иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд мөн адил сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай юм.

Ганц удаагийн бэлэн мөнгөний нөхөн олговор нь нөхөн олговрын зохистой хэлбэр болж чадахгүй байна

“Алтайн Хүдэр” компанийн уурхайн төсөл хэрэгжиж эхэлсэн эхний үе шатанд 22 малчин өрхийг компани нүүлгэн шилжүүлжээ. “Алтайн Хүдэр” компани эдгээр малчдад нүүлгэн шилжүүлсний нөхөн олговорт бэлэн мөнгө олгожээ. Гэтэл бэлчээр нийтийн эзэмшилд байдаг, мөн малчдын амьжиргаа газраас хамааралтай байдаг тохиолдолд бэлэн мөнгө олгох нь зохистой нөхөн олговор болж чадахгүй. Багийн нийт иргэдийн хурлаар ардчилсан байдлаар бэлчээрийг малчдад хуваарилдаг тул малчид нөхөн олговорт авсан бэлэн мөнгөөрөө шинэ өвөлжөө хаваржаа барих зорилгоор газар худалдан авах бололцоогүй юм. Энэхүү кейс судалгаагаар бэлэн мөнгө авсан гэх үндэслэлээр нэг малчин эмэгтэйд шинэ өвөлжөөний газар хуваарилж өгөхөөс татгалзсан шийдвэр гаргасан тохиолдлыг олж тогтоосон¹. Төмрийн хүдрийн үнийн хэлбэлзэл орон нутгийн иргэдийн амьжиргаанд хэрхэн нөлөөлдгийг энэхүү кейс судалгаа харуулж байна. Төмрийн хүдрийн үнэ тогтмол нэг түвшинд байдаггүй тул компаниуд үнэ өссөн богино хугацаанд олборлолтоо эрс нэмэх стратеги барьдаг. Ингэж олборлолтынхоо хэмжээг богино хугацаанд нэмэгдүүлэх нь нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнүүдийг нарийн төлөвлөхөд хүндрэл учруулж улмаар нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд сөрөг нөлөөлөл бий болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Уурхайн богино насжилт сонирхогч талуудын бодит оролцоог хангах хөшүүрэг болж чадахгүй байна

ЕСБХБ-тай байгуулсан зээлийн гэрээний дагуу “Алтайн Хүдэр” компани нүүлгэн шилжүүлсэн малчин өрхүүдийн амьжиргаанд судалгаа хийлгэх зорилгоор зөвлөх компанийг хөлсөлжээ. Судалгааны компани, нүүлгэн шилжүүлсэн малчид уурхайн олборлолттой холбоотойгоор эд хөрөнгөөрөө хохироогүй гэж дүгнэжээ. Үүнээс гадна эдгээр малчдын өрхийн амьжиргааг дэмжих зорилгоор хэд хэдэн нийгмийн хөтөлбөр хэрэгжүүлсэн гэж “Алтайн Хүдэр” компанийн зүгээс мэдээлсэн. Гэвч баримтжуулах судалгааны үеэр уулзаж ярилцсан нэг ч малчин ийм судалгаа хийсэн тухай огт сонсож байгаагүй байна. Судалгааны үеэр уулзаж ярилцсан малчид харин ч уурхайн төсөл хэрэгжиж эхэлсэн тэр үеэс эхлэн тэдгээрийн ахуй амьдралд маш их сөрөг нөлөөлөл бий болсон гэж ярьж байв. Түүнчлэн сонирхогч талуудад мэдээлэл хаалттай байдаг, мөн шүүмжлэл хэлсэн иргэдийг айлган сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлж байсан тохиолдлуудыг тогтоож энэхүү тайланд энэ тухай өгүүлсэн. Компанийн үйл ажиллагааг ил тодоор шүүмжилсэн иргэдийн эсрэг ойролцоогоор долоон гомдол гарган *‘зохион байгуулалттайгаар бусдын нэр хүндэд халдаж, гутаан доромжлох’* гэсэн үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгүүлжээ.

Компанийн зүгээс орон нутгийн иргэдэд ийм байдлаар хандаж байгааг уурхай харьцангуй

¹ “Оюу Толгойн Хяналт” ТББ, Баримтжуулалтын ажлын тайлан, Таян нуурын төмрийн хүдрийн төсөл, 2014 оны 3-р сарын 6-11, хэвлэгдээгүй тайлан.

богино настай гэдгээр тайлбарлаж болох юм. Хүдрийн ордны нөөц харьцангуй богино хугацаанд буюу 10 хүрэхгүй жилийн дотор шавхагдах тооцоо байгаа тул сайн хөрш байх хөшүүрэг компанид төдийлөн байхгүй байна.

ЕСБХБ-ны оролцоо сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж чадахгүй байна

ЕСБХБ-наас санхүүжилт авсан “Алтайн Хүдэр” компани зээлийн гэрээний дагуу ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ)-дад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах үүрэг хүлээсэн байдаг. Уг тайланд компани хамгийн багадаа дөрвөн ГШ-уудыг зөрчсөн гэж дүгнэж байна, тодруулбал: байгаль орчин, нийгмийн менежмент (ГШ 1); орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал (ГШ 4); нүүлгэн шилжүүлэлт ба эдийн засгийн суурьшил алдалт (ГШ 5); мэдээллийн ил тод байдал ба сонирхогч талуудын оролцоо (ГШ 10). ЕСБХБ ба бусад хөгжлийн банкууд хөрөнгө оруулалтын стратегидаа нийгэм, байгаль орчны асуудлуудыг бодлогоор тусгасан байдаг тул бусад хөрөнгө оруулагчдаас ялгарч байдаг. Гэвч кейс судалгаанд нотолсончлон, хэдийгээр ЕСБХБ зээл олгосон төслүүддээ тодорхой хэмжээгээр оролцдог боловч энэ нь нийгмийн болон байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх баталгаа болж чадахгүй байна. Энэ нь үр дүн муутай нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээ авах, эсвэл сонирхогч талуудын оролцоог хангаж чадаагүй тохиолдолд ЕСБХБ-ны зүгээс зохих хариуцлага тооцох механизм байдаггүйтэй холбоотой байж болох юм.

1 Оршил

Гангийн үйлдвэрлэлийн гол түүхий эд болох төмрийн хүдэр нь манай орны эдийн засгийн бүх салбарт чухал үүрэг гүйцэтгэдэг, тухайлбал автомашин, угаалгын машин, хөргөгч зэрэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн барилга, гүүр, зам зэрэг дэд бүтэц хөгжүүлэхэд өргөнөөр ашиглагддаг билээ. Дэлхийн металл үйлдвэрлэлийн 95 хүртэлх хувийг ган эзэлж байна, энэ утгаараа төмрийн хүдрийн зах зээл дэлхийн эдийн засагт шууд нөлөөлж байдаг.² Хятад зэрэг эдийн засаг нь маш хурдацтай өсч байгаа орнуудад шинэ барилга байгууламжийг ихээр барьж байдаг тул эдгээр орнуудад төмрийн хүдрийн хэрэгцээ маш их байдаг. Үүнтэй нэгэн адил эдийн засгийн өсөлт саарахад, хэдхэн жилийн өмнө Америк болон Европын орнуудад тохиолдож байсантай ижил, орон сууцны хөөсөрсөн зах зээл унаж улмаар шинэ байшин барилга баригдахаа больдог. Үүнээс үүдэлтэйгээр төмрийн хүдрийн эрэлт хэрэгцээ огцом буурдаг.

Японы гангийн үйлдвэрлэгчид болон Австрали, Бразилийн төмрийн хүдэр олборлодог томоохон уул уурхайн компаниудын боловсруулсан нэг жилийн жишиг үнэд суурилсан үнийн системийг олон арван жилийн турш төмрийн хүдрийн арилжаанд мөрдөж ирсэн.³ Хятадын эрэлт өссөнтэй холбоотойгоор жишиг үнэд суурилсан үнийн системийг спот зах зээлийн үнийн системээр солих хүртэл буюу 2010 он хүртэл төмрийн хүдрийн үнэ харьцангуй тогтвортой байсан. Спот зах зээл дээрх үнийн спекуляц тоглоом, дэлхийн санхүүгийн хямрал зэрэг хүчин зүйлийн улмаас түүхий эдийн зах зээл дээр арилжаалдаг бусад ашигт малтмалтай харьцуулбал төмрийн хүдэр үнийн хувьд хамгийн эмзэг ашигт малтмал болсон.⁴ Саяхан Хятадад гарсан санхүүгийн дуулиант хэрэг төмрийн хүдрийн эргэн тойронд болсон нь үүний нэг жишээ болох юм, тухайлбал, наймаачид төмрийн хүдрийн овоолгыг барьцаалан нэг бус зээлдэгчээс санхүүжилт авчээ.⁵

2013 оноос хойш төмрийн хүдрийн үнэ ихээхэн унасаар байна. 2014 он гарсаар төмрийн хүдрийн үнэ 38 хувиар буюу 2009 оны 10 дугаар сараас хойш хамгийн бага түвшинд хүртлээ унаад байна.⁶ Нөгөөтэйгүүр, энэхүү үнийн уналтыг Бразил болон Австралиас өртөг багатай төмрийн хүдэр нийлүүлж эхэлсэнтэй холбон үзэж болох юм. Нөгөөтэйгүүр, Хятадын Засгийн газраас барилгын салбарын санхүүжилтэд хязгаарлалт тавьсантай холбоотойгоор гангийн эрэлт хэрэгцээ Хятадад буураад байна.⁷ Шинжээчид энэхүү огцом хийгээд гэнэтийн үнийн уналтыг 'төмрийн эрин үеийн төгсгөл' хэмээн нэрлэжээ.⁸

Төмрийн хүдрийн олборлолт

Төмрийн хүдэр нь Дэлхийн гадаргын 5 хүртэл хувийг эзлэн бүрдүүлж байдаг тул хамгийн их олдоцтой ашигт малтмал бөгөөд дэлхийн улс орнуудад төмрийн хүдрийг их хэмжээгээр олборлодог. Дэлхий дээр төмрийн хүдрийн хамгийн том уурхайнууд Австрали болон Бразил улсуудад байдаг хэдийч Гвинеа, Конго, Сиерра Леоне болон Либер зэрэг орнуудад төмрийн

² Экономист сэтгүүл, "Хүдрийн тухай уламжлалт ойлголт", 2012 оны 10-р сарын 13, < <http://www.economist.com/node/21564559> > (2014 оны 10-р сарын 17).

³ Мөн тэнд.

⁴ Блүүмбэрг Интеллиженс, "Төмрийн хүдрийн зах зээл", Блүүмбэргийн мэдээллийн сангаар дамжуулан хандав.

⁵ Сидней Морнинг Хералд, "Хятадын дуулиан төмрийн хүдрийн үнэд дарамт үзүүлж байна", "Бизнес Өдөр", 2014 оны 6-р сарын 23, < <http://www.smh.com.au/business/mining-and-resources/china-scandal-weighs-on-iron-ore-price-20140623-3andf.html> > (2014 оны 10-р сарын 17).

⁶ "Экономист" сэтгүүл, "Төмрийн хүдрийн олборлолт; буурсан боловч зогсоогүй", 2014 оны 9-р сарын 9, < <http://www.economist.com/news/business-and-finance/21616294-iron-ore> > (2014 оны 10-р сарын 17).

⁷ Ройтерс агентлагийн веб хуудас, "ТОЙМ 2 – Хятадын Н1 гангийн эрэлт хэрэгцээ нийлүүлэлттээс доогуур бөгөөд гангийн үйлдвэрүүд санхүүгийн бэрхшээлтэй тулгараад байна – CISA", 2014 оны 8-р сарын 1, < <http://in.reuters.com/article/2014/08/01/china-steel-idINL4N0Q70J720140801> > (2014 оны 10-р сарын 21).

⁸ Блүүмбэрг агентлагийн веб хуудас, "Төмрийн үнэ 'огцом' унасантай холбоотойгоор Төмрийн эрин үеийг эцэс болгохыг Голдман уриалав", 2014 оны 9-р сарын 10, < <http://www.bloomberg.com/news/2014-09-10/goldman-calls-end-to-iron-age-after-dramatic-drop-in-ore-price.html> > (2014 оны 11-р сарын 28).

хүдрийг мөн адил их хэмжээгээр олборлодог.⁹

Бусад ашигт малтмалын олборлолттой нэгэн адил төмрийн хүдрийн олборлолтоос үүдэлтэйгээр байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл ихээр бий болдогийн зэрэгцээ залилан, сөргөлдөөн, мөн орон нутгийн иргэдийн эрхийг зөрчих зэрэг сөрөг үзэгдлүүд олонтаа гарч байдаг. Гвинеа улсад Симандоу төмрийн хүдрийн уурхайг худалдаж авахад Израилийн тэрбумтан Бени Штайнтецийн эзэмшдэг “Би Эс Жи Ар” (BSGR) компанийн эсрэг үүсгэсэн авлигын хэрэг, эсвэл Энэтхэгт Өмнөд Солонгосын “ПОСКО” (POSCO) компани төмрийн хүдрийн уурхай, гангийн үйлдвэр, мөн холбогдох дэд бүтэц хөгжүүлэхтэй холбоотойгоор 20,000 хүний өмч хөрөнгийг биетээр нүүлгэн шилжүүлж эдийн засгийн суурьшил алдалтд оруулсан зэрэг жишээнүүдийг энд дурдаж болно.¹⁰

Төмөр, зэс эсвэл цагаан тугалга зэрэг үндсэн ашигт малтмалыг алт, мөнгө зэрэг үнэт металлаас ялгаруулж байдаг нэг хүчин зүйл нь олборлолтын хэмжээ байдаг, өөрөөр хэлбэл эдгээр ашигт малтмалыг их хэмжээгээр олборлон тээвэрлэж гадаадад экспортолдог, иймд жин гол хүчин зүйл болж байдаг. Худалдаж авсан, мөн худалдсан төмрийн хүдрийн цэвэр хэмжээ/эзлэхүүн төмрийн хүдрийн зах зээлийн механизм, уурхайн компаниудын сонгосон стратеги болон янз бүрийн сонирхогч талуудад үзүүлэх нөлөөллийг тодорхойлж байдаг.

1.1 Зорилго ба зорилтот бүлгүүд

Төмрийн хүдрийн дэлхийн зах зээлийн шинж чанар уг зах зээл дээр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг компаниудын бизнесийн стратегид шууд нөлөөлж байдаг. Нөгөөтэйгүүр, компанийн стратегийн шийдвэрүүд төмрийн хүдрийн уурхайн олборлолтоос нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж байдаг. Цуврал кейс судалгаа хийх замаар “Үндэстэн дамнасан корпорацуудын судалгааны төв” (SOMO) нь дэлхийн олон оронд олборлолт хийж байгаа төмрийн хүдрийн уурхайнуудын сөрөг нөлөөллийг тогтоож тайлбарлах, эдгээр сөрөг нөлөөлөл компанийн бизнесийн стратегиуд болон дэлхийн төмрийн хүдрийн зах зээлээс хэрхэн хамаарч байдгийг харуулахаар зорьж байна. Тухайн компанийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх замаар уурхайн ажилчид, орон нутгийн иргэд, мөн байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байдаг нийтлэг хүчин зүйлүүдийг тогтоох зорилтыг бид тавьж байна. Ийм төрлийн мэдээллийг төмрийн хүдрийн уурхайн шинэ төсөлд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа санхүүжүүлэгч байгууллагууд, төмрийн хүдрийн эсвэл гангийн салбарт хөрөнгө оруулалт хийх асуудлыг судалж байгаа (тулхтай хөгжлийн үзэл баримтлалтай) хөрөнгө оруулагчид төсөл санаачлагчийн үйл ажиллагаанд магадлан шинжилгээ хийх үйл явцдаа ашиглаж болохын зэрэгцээ төмрийн хүдэр олборлох төслүүдийн сөрөг нөлөөлөлд өртсөн оролцогч талуудтай ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд, мөн уг асуудлыг сонирхдог хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мөн ашиглах боломжтой юм.

Энэхүү товч тайлан нь цуврал кейс судалгааны эхний кейс судалгаа бөгөөд тайланд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)-аас санхүүжилт авч Таян нуурын уурхайд олборлолт хийж байгаа Монголын “Алтайн Хүдэр” компанийн үйл ажиллагааны талаар өгүүлсэн болно.

⁹ Mining-Technology.com веб хуудас, “Дэлхийн хамгийн том төмрийн хүдрийн уурхайнууд”, 2014 оны 2-р сарын 19, < <http://www.mining-technology.com/features/featurethe-worlds-11-biggest-iron-ore-mines-4180663/>> (2014 оны 10-р сарын 17); Майниг Вийкли веб хуудас, “Уул уурхайн компаниуд Баруун Африкийг төмрийн хүдрийн хамгийн том дараагийн очих ёстой газар хэмээн онилж байна”, 2013 оны 10-р сарын 25, <http://www.miningweekly.com/article/miners-set-sights-on-west-africa-as-the-next-big-iron-ore-destination-2013-10-25> (2014 оны 10-р сарын 17).

¹⁰ CorpWatch веб хуудас, “Гвинеа дахь төмрийн хүдэртэй холбоотой авилгын хэргээр “Би Эс Жи Ар” компани шалгагдаж байна”, 2013 оны 10-р сарын 4, < <http://www.corpwatch.org/article.php?id=15893>> (2014 оны 10-р сарын 17); ЭЗХАХБ-ын Хяналт буюу OECDWatch веб хуудас, Кейстэй холбоотой мэдээллийн сан, “Лок Шакти Абхиян болон бусад ПОСКО-гийн эсрэг”, огноогүй, < http://oecdwatch.org/cases/Case_260> (2014 оны 10-р сарын 17).

1.2 Арга зүй

Уг кейс судалгааг холбогдох тайлан, баримт бичгүүдийг судлах, мөн уурхайн нөлөөллийн бүсэд очиж газар дээр нь баримт цуглуулах замаар хийв. Монгол орны төмрийн хүдрийн салбарын тухай мэдээлэл (Бүлэг 1) болон “Алтайн Хүдэр” компанийн тухай товч танилцуулгыг (Бүлэг 2) судалгааны тайлангууд, шинжээчдийн тайлан, хэвлэл мэдээллийн агентлагууд, рейтингийн агентлагууд, төрийн бус байгууллагууд (ТББ)-ын мэдээ мэдээлэл зэрэг эх үүсвэрээс олж цуглуулсан болно. Компанийн бизнесийн стратегид үнэлгээ дүгнэлт хийхэд хэд хэдэн шинжилгээний арга хэрэгслийг ашигласан болно.

“Алтайн Хүдэр” компанийн төмрийн хүдрийн уурхайн нөлөөллийн тухай бүлэг нь 2014 оны 8 дугаар сард “Үндэстэн дамнасан корпорацуудын судалгааны төв” (SOMO), “Төв болон Зүүн Европын Банкны хяналт Сүлжээ” (CEE Bankwatch), “Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбоо” ТББ, “Оюу Толгойн Хяналт” ТББ-ын хамтарсан судалгааны багийн нэг долоо хоногийн хугацаанд газар дээр нь олж авсан мэдээлэл дээр үндсэндээ суурилсан бөгөөд уг баримтжуулах ажлын тайланг тусад нь гаргасан болно. Судалгааны баг Говь-Алтай аймгийн Цээл сумын Баянгол, Дэрстэй багуудад очиж ажилласан.¹¹ Ингэхдээ судалгааны баг Цээл сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнууд, Дэрстэй, Баянгол багийн Засаг дарга нар, орон нутгийн хоршооны дарга, мөн эдгээр хоёр багийн 20 гаруй малчидтай уулзаж ярилцлага хийсэн. Үүнээс гадна судалгааны баг “Алтайн хүдэр” компанийн хэрэгжүүлж буй төслийн талбай, тухайлбал одоогоор барилгын ажил нь явагдаж байгаа уурхайгаас Хятадын хил рүү төмрийн хүдэр тээвэрлэх хатуу хучилттай авто зам, мөн Цээл суманд баригдаж байгаа хүүхдийн цэцэрлэгийн барилгын газар дээр очиж нөхцөл байдалтай танилцсан. Мөн түүнчлэн Улаанбаатар хотод Монгол Улс дахь ЕСБХБ-ны Суурин төлөөлөгчийн газрын холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцсан. Уг судалгаа нь 2014 оны 3 дугаар сард “Оюу Толгойн Хяналт” ТББ, “Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбоо” ТББ болон “Цээл сумын уугуул иргэдийн зөвлөл”-тэй хамтарч хийсэн эхний судалгааны үргэлжлэл нь байсан юм.

Энэхүү тайлангийн төслийг “Үндэстэн дамнасан корпорацуудын судалгааны төв”-ийн журмын дагуу “Алтайн Хүдэр” компани болон ЕСБХБ-д тус тус хүргүүлсэн болно.

1.3 Хязгаарлалт

Энэхүү кейс судалгаа нь агуулгын хувьд судалгааны ажил бөгөөд төмрийн хүдэр олборлох салбарт гардаг тогтвортой хөгжил, хүний эрхтэй холбоотой асуудлуудыг тодорхойлох зорилготой байсан. Иймд дараахь хязгаарлалт байгааг харгалзан үзэх хэрэгтэй. Нэгдүгээрт, компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөллийн талаар олж мэдсэн зүйл нь Цээл сумын цөөн тооны иргэдтэй хийсэн ярилцлагууд дээр голдуу үндэслэсэн болно. Иймд Таян нуурын уурхайн төслөөс үүдэлтэй хэмээн тогтоосон нөлөөлөл нь Цээл сумын бүх иргэдэд тохиолдсон нийтлэг туршлага болж чадахгүй тул судалгаагаар тогтоосон үр дүнг нийтлэг үр дүн гэж үзэх боломжгүй юм. Хоёрдугаарт, тайлан бичиж байх тухайн үед судлаачдад олдсон мэдээ мэдээлэл дээр үндэслэн энэхүү тайланг боловсруулсан. Хурлын тэмдэглэл, зөвлөх үйлчилгээний компанийн тайлангууд, мөн бусад эх сурвалж байгааг судлаачид мэдэж байгаа боловч эдгээр баримт бичиг судлаачдад хаалттай байсан. Эцэст нь, энэхүү кейс судалгаагаар “Алтайн Хүдэр” компанийн үйл ажиллагаа Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийх зорилго тавиагүйн зэрэгцээ аливаа хууль эрх

¹¹ Засаг захиргааны нэгжийн хувьд Монгол Улс 21 аймагт хуваагддаг бөгөөд аймаг нь сум, сум бүр засаг захиргааны анхан шатны нэгж болох багаас бүрддэг.

зүйн үр дагавар агуулаагүй гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй.

1.4 Тайлагийн бүтэц

Тайлангийн оршил хэсгийн дараа Бүлэг 2-т Монгол дахь төмрийн хүдэр олборлох салбарын тухай, тэр дундаа нийгэм, байгаль орчны нөлөөллийн талаар товч өгүүлсэн болно. Бүлэг 3-т “Алтайн Хүдэр” компанийн тухай товч танилцуулга, мөн компанийн бүтэц, өмчлөлийн бүтэц, компанийн бизнесийн стратегийн талаар дурдсан. Бүлэг 4-т “Алтайн Хүдэр” компанийн төмрийн хүдрийн уурхайн нөлөөллийн талаар олж тогтоосон зүйлийн талаар өгүүлэхийн зэрэгцээ эдгээр нөлөөлөл Монгол дахь төмрийн хүдэр олборлох салбар, мөн “Алтайн Хүдэр” компанийн бизнесийн стратегиас хэрхэн хамаарч байгаа талаар өгүүлсэн. Бүлэг 5-т ЕСБХБ-ны нийгэм, байгаль орчны стандартуудад үндэслэн уурхайн олборлолтос үүдэлтэй нөлөөлөлд дүн шинжилгээ хийсэн. Сүүлчийн буюу Бүлэг 6-т ерөнхий дүгнэлт, мөн энэхүү кейс судалгаан дээр үндэслэн ямар сургамж авч болох тухай дурдсан болно.

2 Монгол дахь төмрийн хүдэр олборлох салбар

Энэхүү кейс судалгааг Монголд хийв. Дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүйгээр өгүүлэх Монголын “Алтайн Хүдэр” компанийн төмрийн хүдрийн уурхайн нөлөөллийг Монгол орны нөхцөл байдал, мөн Монголын уул уурхайн салбарын шинж чанар, түүхтэй холбон ойлговол зохино.

2.1 Монголын уул уурхайн салбар

Хэдийгээр Монгол орны эдийн засаг нүүдлийн мал аж ахуй, мөн хөдөө аж ахуй дээр суурилж ирсэн уламжлалтай боловч сүүлийн жилүүдэд олноор олж илрүүлсэн ашигт малтмалын их нөөц баялаг нь тус орны эдийн засгийг ихээхэн өөрчилсөн билээ.¹² Монгол орон нь асар их нөөцтэй зэс, алт, нүүрс болон төмрийн хүдрийн ордуудтай бөгөөд сүүлийн арван жилд хэд хэдэн томоохон уурхайнууд олборлолтоо эхлүүлсэн билээ. Өмнийн Говьд орших зэс, алтны Оюу Толгойн орд нөөцөөрөө дэлхийд томоохон ордуудын тоонд багтаж байна. 2013 онд олборлолт хийж эхэлсэн Оюу Толгойн уурхайн төслийг Рио Тинто компани хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь Монголын түүхэнд хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн төсөл юм.¹³ 6 тэрбум тонн нүүрсний нөөцтэй Таван Толгойн нүүрсний уурхайд сүүлийн хэдэн жилд маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийгээд байна.

Энэ хоёр том уурхайн төслийг хэрэгжүүлж эхэлснээр 2009-2011 оны хооронд өргөн хэрэглээний барааны хэрэглээ маш ихээр өссөн. Уул уурхайн салбарт их хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотойгоор 2011 онд Монголын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) хамгийн их буюу 17,5 хувиар өсч улмаар Монгол улс дэлхийд хамгийн хурдан өсч байгаа эдийн засагтай орнуудын нэг нь болсон юм.¹⁴ Уул уурхайн энэ хоёр том төсөл, мөн бусад уул уурхайн төслүүд, тэдгээрийг дагасан ажил үйлчилгээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт 2011, мөн 2012 онд үлэмж хэмжээгээр өссөн. 2006 оноос 2011 оны хооронд Монголын хөрөнгийн биржийн гол индекс болох Топ 20 индекс арав дахин өсөхийн зэрэгцээ инфляц ч мөн адил өссөн.¹⁵ Олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК), ЕСБХБ зэрэг хөгжлийн банкууд энэ огцом өсөлтийн үед хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн.

Гэвч 2012 оноос хойш энэхүү өгцөм өсөлт ихээхэн саарсан. 2013 онд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх онтой харьцуулбал бараг хоёр дахин буурсан. Рио Тинто компани, Монголын Засгийн газрын хооронд олборлолтын зардал, Оюу Толгойн компанийн татварын асуудлаар үүссэн маргаан, ашигт малтмалын тухай хуульд орсон өөрчлөлт, мөн 106 тусгай

¹² АНУ-ын ТТГ-ын веб хуудас, Дэлхийн тоо баримт, “Монгол Улс”, огноогүй, < <https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/geos/mg.html> > (2014 оны 10-р сарын 17).

¹³ Invest in Mongolia веб хуудас, “Алтны уурхай”, огноогүй, < <http://www.investinmongolia.org/index.php/invest/gold> > (2014 оны 10-р сарын 17).

¹⁴ Монгол дахь Дэлхийн Банк Групп, Монголын эдийн засгийн тойм, 2013 оны 11-р сар, < http://www-wds.worldbank.org/external/default/WDSCContentServer/WDSP/IB/2013/11/07/000442464_20131107125022/Rendered/PDF/826050WP0Mong00Box379865B00PUBLIC0.pdf > (2014 оны 10-р сарын 17), хуудас 11.

¹⁵ Блүүмберг агентлагийн веб хуудас, “Эдийн засгийн өсөлт 20 хувьд хүрэхээр байгаа тул Монгол улс ам.долларын бондны анхны арилжаагаа хойшлуулж байна”, 2011 оны 10-р сарын 27, < <http://www.bloomberg.com/news/2011-10-27/mongolia-delays-dollar-bond-sale-as-economy-set-for-20-growth.html> > (2014 оны 10-р сарын 17).

зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа царцаахад хүргэж улмаар эдийн засгийн өсөлт саарах болсон.¹⁶ Хувьцаа гаргахаар төлөвлөж байсан нэлээдгүй олон компаниуд азнах шийдвэр гаргасан бол Монголын нийт эдийн засаг эрс суларсан.

2.2 Монгол дахь төмрийн хүдрийн олборлолт

Монгол орон газарзүйн байршлын хувьд Хятадтай хил залгадаг тул Монголын төмрийн хүдрийн салбар үндсэндээ хөрөнгө оруулагч нарын сонирхлыг ихээр татаж байдаг. Монголд олборлосон бараг бүх төмрийн хүдрийг төмрийн хүдрийг маш ихээр хэрэглэдэг хөрш Хятад улсын гангийн үйлдвэрүүдэд экспортолдог. Хэрэглэгчдийн худалдан авах үнэд тээвэрлэлтийн зардал чухал нөлөө үзүүлж байдаг тул Бразил, Австрали зэрэг төмрийн хүдэр экспортлодог бусад гол өрсөлдөгчидтэй харьцуулбал Монгол харьцангуй давуу талтай байдаг. Ялангуяа Хятадын Өвөр Монголын Өөртөө Засах Орон, мөн Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орны барилгын салбарын гангийн хэрэгцээг Монголын төмрийн хүдрээр хангаж байна, учир нь Хятадын эдгээр газар нутагт Хятадын зүүн талын усан боомтуудаар импортоор оруулсан төмрийн хүдрийн тээвэрлэлтийн зардал маш өндөр байдаг юм.

Монгол нь дэлхийн хэмжээнд төмрийн хүдэр олборлогч том орноор тооцогдохгүй. Хэдийгээр зэс, нүүрс нь Монголын эдийн засагт хамгийн их хувь нэмэр оруулдаг ашигт малтмал боловч төмрийн хүдэр экспортын хэмжээгээрээ гуравт ордог бөгөөд 2013 онд Монголын нийт экспортын 15 орчим хувийг эзэлж байв.¹⁷ Нийт төмрийн хүдрийн экспортын үнийн дүн 2013 онд 700 сая ам.доллартай тэнцэж байв.

2009-2011 оны уул уурхайн салбарын огцом өсөлтийн үед төмрийн хүдэр олборлох салбарт хөрөнгө оруулагчид анхаарлаа ихээхэн хандуулж байсан бөгөөд ЕСБХБ, мөн Хятадын Хөрөнгө оруулалтын корпорац төмрийн хүдэр олборлодог зарим том уул уурхайн компаниудад хэдэн сая ам. доллараар хэмжигдэх хөрөнгө оруулалт хийсэн билээ. Уул уурхайн салбарын огцом өсөлтийн үе 2012 он гэхэд дуусгавар болсноор бусад ашигт малтмалтай нэгэн адил төмрийн хүдрийн салбарт хөрөнгө оруулалт хийх сонирхол буурсан. Монгол дахь уул уурхайн салбарын огцом өсөлтийн үе дэлхийн зах зээл дээр төмрийн хүдрийн үнэ унаж эхэлсэн үетэй, нэн ялангуяа 2013 оны 8-р сараас хойш үнэ огцом унаж эхэлсэн үетэй давхацан нэгэнт цагаа өнгөрөөсөн билээ. Зах зээлийн таагүй нөхцөл байдлаас болж Монголын бусад хоёр жижиг төмрийн хүдэр олборлодог компани үйл ажиллагаагаа зогсоогоод байна.¹⁸

2.3 Нийгэм болон байгаль орчны нөлөөлөл

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хамгийн сүүлд гаргасан тайландаа Монголд уул уурхайн олборлолтоос байгаль орчинд үүсч байгаа нөлөөллийн талаар дэлгэрэнгүй авч үзэж, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг ихээр олгосны улмаас байгаль орчин маш их

¹⁶ Блүүмберг агентлагийн веб хуудас, “Монгол улс хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг сэргээхээр төлөвлөж байна”, 2014 оны 4-р сарын 28, < <http://www.bloomberg.com/news/2014-04-28/mongolia-prepares-to-restore-mining-licenses-in-investment-boost.html>> (2014 оны 10-р сарын 17); Ройтерс агентлагийн веб хуудас, “Тусгай тайлан: татварын асуудлын хувьд Монгол нь архирсан хулгана л юм”, 2013 оны 7-р сарын 6, < <http://www.reuters.com/article/2013/07/16/us-dutch-mongolia-tax-idUSBRE96F0B620130716>> (2014 оны 10-р сарын 21).

¹⁷ Монголиан Майнинг Журнал, “Монголын төмрийн хүдрийн салбарын эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ”, 2014 оны 3-р сар, < eri.mn/research/ERI/ERI_Iron_Ore.pdf>, (2014 оны 10-р сарын 17), хуудас 2.

¹⁸ Мөн тэнд.

доройтсон хэмээн дүгнэжээ.¹⁹ Ашигт малтмалын тээвэрлэлтээс болж байгаль орчин ихээр доройтож байгаа талаар уг тайланд дурдахын сацуу хөрс, бэлчээр бохирдсоны улмаас амьсгалын замын өвчлөл гарах, нүүрс болон бусад ашигт малтмалыг тээвэрлэж байгаа зам дагуу амьдардаг иргэд амьжиргааны эх үүсвэрээ тогтвортойгоор залгуулахад хүндрэл үүсч байгаа тухай цохон тэмдэглэжээ. Францын Лё Монд сонины бичиж байгаагаар уурхайн олборлолт экосистемийн тэнцвэртэй байдлыг алдагдуулах, мөн Монголын хөдөө тал нутаг улам их цөлжихөд хүргэж байна.²⁰ Уурхайн олборлолт хийхэд их хэмжээний ус шаардагддаг тул томоохон гол мөрний гольдрилыг өөрчлөх, Нэгдсэн Үндэсний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу ЮНЕСКО-гоос дэлхийн өвд бүртгэсэн Орхоны хөндий зэрэг соёлын дурсгалт газруудад аюул учруулж байна. Уурхайн талбайгаас гарах дуу чимээ, мөн амьдрах орчин дундуур нь гарсан тээвэрлэлтийн зам нь зэрлэг ан амьтанд сөргөөр нөлөөлж байна. Уурхайнууд үйл ажиллагаагаа зогсоохдоо олборлолт хийж байсан газраа гол төлөв нөхөн сэргээлт хийлгүйгээр орхиж явдаг тул байгаль орчин доройтож шарх сорвитой мэт эвдэрсэн газар л үлддэг.

Уурхайн олборлолт орон нутгийн ард иргэдийн амьжиргаанд мөн адил сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үзэж байгаагаар бэлчээр хумигдсаны улмаас уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхлэхэд хүндрэлтэй болж байгаатай холбоотойгоор зарим бүс нутагт нүүдэлчин малчдын тоо 56 хувиар буурсан байна. Аревагийн ураны уурхайн ойр орчим нутагладаг малчдын малаас ургийн гажигтай төл гарах тохиолдол ихсэж байгаа талаар Лё Монд сонинд мөн бичжээ.²¹ Говийн бүс нутагт уурхай, мөн уурхайг дагасан дэд бүтцээс болж маш их хэмжээний тоосжилт үүсч байгаа бөгөөд тоосжилтын улмаас бэлчээр бохирдох, мөн малчид, мал амьсгалын өвчлөлөөр өвчлөх тохиолдол нэмэгдэх болжээ. Энэ бүгдээс болж бүс нутгийн ихэнх малчид илүү үржил шимтэй бэлчээр бараадаж хойд зүг рүү олноороо нүүжээ.

¹⁹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл, Улаанбаатар хот, 2013 он, < <http://www.asiapacificforum.net/members/full-members/mongolia/downloads/annual-reports/2013>> (2014 оны 10-р сарын 17) хуудас 9.

²⁰ Лё Монд сонины веб хуудас, "Монгол улс; Эльдorado алга байна", огноогүй, < http://www.lemonde.fr/a-la-une/visuel/2014/09/06/mongolie-l-eldorado-n-existe-pas_4464498_3208.html> (2014 оны 10-р сарын 17).

²¹ Мөн тэнд.

3 “Алтайн Хүдэр” ХХК-ийн тухай товч танилцуулга

Энэ бүлэгт төмрийн хүдэр олборлодог Монголын уул уурхайн “Алтайн Хүдэр” компанийн талаар товч өгүүлнэ. Компанийн бүтэц, өмчлөлийн бүтэц, санхүү зэрэг ерөнхий мэдээлэл өгсний дараа бүлгийн хоёр дахь хэсэгт компанийн бизнесийн стратегийн тухай өгүүлэх болно. Стратегийн дүн шинжилгээний зорилго нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа, мөн Бүлэг 4-т дурдсан нийгэм, байгаль орчны нөлөөллийг тодорхойлж байгаа хэд хэдэн хүчин зүйлийг тодорхойлоход оршиж байна.

“Алтайн Хүдэр” компани нь Монголдоо төмрийн ордны хайгуул болон олборлолт эрхэлдэг хоёр дахь том компани юм.²² Тус компани 2006 оноос Таян нуурын төмрийн хүдрийн уурхайг эзэмшиж байгаа ба одоогоор олборлолтоо үргэлжлүүлэн явуулсаар байна.²³ Таян нуурын орд нь Монголын нийслэл Улаанбаатар хотоос баруун өмнө зүгт ойролцоогоор 1300 км-т, Хятадын хилээс ойролцоогоор 168 км-т байрладаг. Компани төмрийн хүдрийн бүтээгдэхүүнийг худалдах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдгээс гадна Хятадын баруун хэсэгт байрладаг гангийн үйлдвэрүүдэд бүтээгдэхүүнээ экспортолдог.²⁴ Компанийн албан ёсны танилцуулгаас үзэхэд, Таян нуурын төсөл жилд 2,3 сая тонн олборлох хүчин чадалтай бөгөөд энэ нь сүүлийн таван жилд зургаа дахин өссөн үзүүлэлт юм, нийт нөөцийн хэмжээ нь 38 хувийн төмрийн хүдрийн агууламжтай 91,7 сая тонн байна.²⁵ Компанийн төмрийн хүдрийн экспортын хэмжээ Монголын нийт экспортын 33 хувийг эзэлж байна.

3.1 Компанийн болон өмчлөлийн бүтэц

“Алтайн Хүдэр” нь Монголын бизнес эрхлэгч ноён Базарын Раднаабазарын дангаараа эзэмшдэг хувийн компани юм.²⁶ Уг компанийн дүрмийн санд хөрөнгө оруулалт хийсэн ЕСБХБ компанийн 5 хувийн буюу цөөнх хувьцааг эзэмшдэг.²⁷

Сүүлийн жилүүдэд “Алтайн Хүдэр” ХХК-ийн компанийн хийгээд өмчлөлийн бүтэц байнга өөрчлөгдөж байсан бололтой. “Алтайн Хүдэр” компанийн бүтцийн талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг 2014 оны 3 дугаар сард танилцуулсан компанийн албан ёсны танилцуулгаас л олж болох юм.²⁸ Гэвч 2014 оны 11 дүгээр сард энэхүү тайлангийн төсөлд

²² “Си Ар Ю” (CRU) Групп, “Төмрийн хүдэр: Монголын потенциалыг үнэлэх нь”, Улаанбаатар, 2012 оны 9-р сарын 3-5, Frontier Invest Mongolia 2012 он, Жон Жонсон, CRU Хятад дахь салбарын Гүйцэтгэх Захирал < <http://www.frontier.mn/index.php/research/full-reports/category/5-expert-series-2012?download=57:assessing-mongolia-iron-ore-potential>> (2014 оны 11-р сарын 24), хуудас 13.

²³ “Алтайн Хүдэр” компанийн веб хуудас, Бидний тухай, “Алтайн Хүдэр” ХХК, огноогүй, < <http://www.altainkhuder.mn/content/24.htm>> (2014 оны 10-р сарын 17).

²⁴ Мөн тэнд.

²⁵ “Эм Ар Си” (MRC), Монголиан Ресурс Корпорэйшн, “Майнс энд Мани Хонгонг 2014” олон улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын үзэсгэлэнгийн үеэр хийсэн танилцуулсан powerpoint танилцуулга, 2014 оны 3-р сарын 25-27, < http://www.minesandmoney.com/hongkong/wp-content/uploads/2014/04/26Mar_S2_1230_Javkhanbazar-Radnaabazar_Mongolian-Resource-Corp.pdf> (2014 оны 10-р сарын 21).

²⁶ Ройтерс агентлагийн веб хуудас, “TEXT-S&P Монголиан Ресурс Корпорэйшн-д ‘В-’ төлөв байдал тогтвортой” гэсэн үнэлгээ өгөв”, 2012 оны 10-р сарын 8, < <http://www.reuters.com/article/2012/10/08/idUSWLA441720121008>>, 2014 оны 10-р сарын 21.

²⁷ “Эм Ар Си” (MRC), Монголиан Ресурс Корпорэйшн, “Майнс энд Мани Хонгонг 2014” олон улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын үзэсгэлэнгийн үеэр танилцуулсан powerpoint танилцуулга, 2014 оны 3-р сарын 25-27, < http://www.minesandmoney.com/hongkong/wp-content/uploads/2014/04/26Mar_S2_1230_Javkhanbazar-Radnaabazar_Mongolian-Resource-Corp.pdf> (2014 оны 10-р сарын 21).

²⁸ Мөн тэнд.

өгсөн хариу захидалдаа уг мэдээлэл хуучирсан гэж компаниас онцолсон.²⁹ Иймд компанийн өнөөгийн бүтэц ямар байгаа нь тодорхой бус хэвээр байна.

2014 оны 3 дугаар сард танилцуулсан компанийн бүтцээр бол “Алтайн Хүдэр” ХХК-ийг Люксембургд төвтэй “Монголиан Ресурс Корпорэйшн” ХХК зуун хувь эзэмшиж байсан. Группын эцсийн толгой компани нь Кайманы Аралд бүртгэлтэй “Эм Ар Си” (MRC, Монголиан Ресурс Корпорэйшн) компани бөгөөд уг компани Британийн Виржинийн Арлуудад бүртгэлтэй “Милльон Вижн Групп Лимитэд” (Million Vision Group Limited) компанийг мөн адил хянадаг байсан. Люксембург, Кайманы Арал болон Британийн Виржинийн Арлуудыг гол төлөв нууц улс гэж үздэг.³⁰

Гадаадын зөвлөх компанийн зөвлөсний дагуу олон улсын хөрөнгийн зах зээл дээр хувьцаа гаргах бэлтгэл ажлын хүрээнд уг бүтцийг сонгосон гэж компанийн зүгээс мэдэгдсэн.³¹ 2012 онд “Алтайн Хүдэр” нь Австралийн “Макквейэр Групп” болон “Банк оф Америка” хоёрыг Хонконгийн хөрөнгийн бирж дээр компанийн хувьцааг нийтэд санал болгох арилжааг (IPO) зохицуулах олон улсын зохицуулагчаар томилсон.³² 2012 оны дөрөв дүгээр улиралд багтаан хувьцааг нийтэд санал болгохоор төлөвлөж байсан боловч өнөөг хүртэл хувьцаа гаргаагүй байна. Хувьцаа гаргахыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан тул уг бүтэц хамаагүй болсон хэмээн “Алтайн Хүдэр” компаниас тайлбарласан.³³

Компанийн хувьцааг нийтэд санал болгох бэлтгэл ажил эхлэхээс өмнө “Дойче Банк” өөрийн хөрөнгө оруулалтаа компаниас татсантай холбоотойгоор “Алтайн Хүдэр” компанийн өмчлөлийн бүтцэд хэд хэдэн өөрчлөлт орсон. “Дойче Банк” 2011 он хүртэл “Эм Ар Си” компанийн гол хувьцаа эзэмшигч болох “Евро 7 Инвестмент” компанид хувь эзэмшиж байсан.³⁴ “Дойче Банк”-ны 2010 оны жилийн тайланд дурдсанчлан “Дойче Банк” тайлант хугацаанд уг компанийн 21,2 хувийг эзэмшиж байв.³⁵ 2011 онд эдгээр хувьцааг ноён Базарын Раднаабазарын бизнесийн түншүүдэд зээл олгох замаар шилжүүлжээ. Уг арилжааны үр дүнд компанид бүтцийн өөрчлөлт хийж, улмаар “Евро 7 Инвестмент”, “Ийстерн Металс” ХХК, Монголын Худалдаа Хөгжлийн Банк, мөн “Ти Ди Би Капитал” ХХК “Монголиан Ресурс Корпорэйшн” ХХК (Люксембургт бүртгэлтэй аж ахуйн нэгж)-д эзэмшиж байсан хувьцаагаа “Эм Ар Си”-д (Кайманы Аралд бүртгэлтэй аж ахуйн нэгж) зарсан байна.³⁶

ЕСБХБ-ны санхүүжилт

2012 онд ЕСБХБ-ны ТУЗ-өөс Таян нуурын уурхайг хөгжүүлэхэд зориулж 30 сая ам.долларын хугацаатай зээлийг “Алтайн Хүдэр” компанид олгох шийдвэр гаргаж, 25 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг “Алтайн Хүдэр” ХХК-ийн дүрмийн санд хийжээ.³⁷ Ингэхдээ 15 сая

²⁹ “Алтайн Хүдэр” компаниас энэхүү тайлангийн төсөлд өгсөн хариу, 2014 оны 11-р сарын 24-ний өдөр авсан цахим захиа.

³⁰ Санхүүгийн нууцлаг байдлын индекс-ийн веб хуудас, “Санхүүгийн нууцлаг байдлын индекс – 2013 оны үр дүн”, огноогүй, **Error! Hyperlink reference not valid.** / introduction/fsi-2013-results> (2014 оны 10-р сарын 21).

³¹ Алтайн Хүдэр” компаниас энэхүү тайлангийн төсөлд өгсөн хариу, 2014 оны 11-р сарын 24-ний өдөр авсан цахим захиа.

³² “Воол Стрийт” сэтгүүлийн блог хуудас, “Макквейэр Монголын IPO гаргахад тэргүүлэх үүрэгтэйгээр оролцох боллоо”, Дийл Жорнал Австралиа, 2012 оны 5-р сарын 23, < <http://blogs.wsj.com/dealjournal/australia/2012/05/23/macquarie-lands-lead-role-on-1-billion-mongolia-ipo/>> (2014 оны 11-р сарын 27).

³³ “Алтайн Хүдэр” компаниас энэхүү тайлангийн төсөлд өгсөн хариу, 2014 оны 11-р сарын 24-ний өдөр авсан цахим захиа.

³⁴ Ройтерс агентлагийн веб хуудас, “TEXT-S&P Монголиан Ресурс Корпорэйшн-д ‘B-’ төлөв байдал тогтвортой” гэсэн үнэлгээ өгөв”, 2012 оны 10-р сарын 8, < <http://www.reuters.com/article/2012/10/08/idUSWLA441720121008>>, 2014 оны 10-р сарын 21.

³⁵ Дойче Банк, “Дойче Банк” ХК-ийн 2010 оны Жилийн санхүүгийн тайлан ба Удирдлагын тайлан < https://www.deutschebank.de/ir/en/download/Annual_Financial_Statements_and_Management_Report_of_Deutsche_Bank_AG_2010.pdf> (2014 оны 11-р сарын 24).

³⁶ Люксембургийн Хууль тогтоомжийн үйлчилгээний төв, Нийгэмлэгүүд, Холбоодын Тайлан, Люксембургийн Их Гүнт Улсын дурсгалын албан ёсны сэтгүүл, 2013 оны 7-р сарын 8.

³⁷ ЕСБХБ, 2012 оны 1-р сарын 31-ний өдрийн ТУЗ-ийн Хурлын тэмдэглэл, < Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл – Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

ам.долларыг хөрөнгийн зах зээл дээр бүртгүүлэхээр төлөвлөж байсан толгой компанийн хувьцаа авахад, 10 сая ам.долларыг ЕСБХБ-ны эзэмших хувь буурахаас хамгаалах зорилгоор хоёр хувааж тус тус олгожээ.

Уг хөрөнгө оруулалт нь Төв болон Зүүн Европ, мөн Төв Азийн орнуудыг зах зээлийн эдийн засагт шилших шилжилтэд дэмжлэг үзүүлэх зорилготой ажээ.³⁸ ЕСБХБ-ны “Уул уурхайн салбарт баримтлах бодлого”-д дурдсанчлан, Банк нь уул уурхайн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх замаар ‘шилжилтийн сорилтуудыг’ даван туулахад дэмжлэг үзүүлэхийг зорьж байна. Эдгээр сорилтод стратегийн ордууд дахь төрийн оролцоо; зах зээлийн төвлөрөл; худалдааны саад тогтор; дэд бүтэц хөгжөөгүй байдал; хуучирсан технологи; сул институцууд, ил тод байдлын хомсдол; мөн хууль эрх зүйн зохицуулалт олон улсын стандартуудад үл нийцсэн байдал зэргийг хамруулсан байна.

‘Хэд хэдэн үйлдвэрлэлийн салбарт гол түүхий эд болдгоороо ган нийт эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг’ тул ЕСБХБ өөрийн үйл ажиллагаа явуулдаг улс орнуудад төмрийн хүдэр, коксжих нүүрс олборлоход санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байна.³⁹ ЕСБХБ нь уул уурхайн салбарт тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, олон улсын стандартуудыг хангасан хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг мөн адил зорьж байна.

Уг төсөл ЕСБХБ-ны Монголд баримталж байгаа стратегид мөн нийцэж байгаа ба 2006 оноос 2012 оны хооронд нийт 52 төсөлд Банкны зүгээс хөрөнгө оруулалт хийжээ.⁴⁰ Бусад зорилтуудын хувьд ЕСБХБ нь *‘хувийн эзэмшилтэй уул уурхайн компаниудад зээл олгох, дүрмийн санд нь хувь эзэмших, байгаль орчин, ил тод байдал, корпорацийн засаглалын өндөр стандартуудад нийцсэн үйл ажиллагаа явуулахыг шаардах замаар байгалийн баялгийн салбарт тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг тусалцаа үзүүлэх’* зорилттой ажээ.⁴¹

3.2 Санхүү

“Алтайн Хүдэр”, мөн түүний толгой компани болох “Эм Ар Си” компани жилийн тайлан эсвэл санхүүгийн тайлангаа огт гаргаж байгаагүй.

2012 онд бонд гаргах бэлтгэлээ хангаж байх үеэр “Мүүдис”, мөн “Стандарт энд Пуур” (S&P) рейтингийн агентлагууд компанид “ВЗ” болон “В-” гэсэн үнэлгээг тус тус өгч байсан бол компани бондоо гаргаагүй билээ.⁴² “Мүүдис” өөрийн өгсөн үнэлгээгээ тайлбарлахдаа компани их хэмжээний зээлтэй, ингэхдээ компанийн хувьцаа эзэмшигчид хийгээд ЕСБХБ зэрэг холбогдох талуудад дийлэнх хэмжээний өртэй хэмээн онцолжээ.⁴³

2012 оны 6-р сарын байдлаар “Дойче Банк”-ны хувьцааг худалдан авахад үүссэн өр

<http://www.ebrd.com/downloads/board/BDSM1202w.pdf> (2014 оны 11-р сарын 27).

³⁸ ЕСБХБ, Уул уурхайн салбарт баримтлах бодлого, 2012 оны 10-р сарын 17-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар баталсан, < <http://www.ebrd.com/downloads/policies/sector/mining-operations-policy.pdf> > (2014 оны 10-р сарын 21).

³⁹ Мөн тэнд, хуудас 6.

⁴⁰ ЕСБХБ, Монгол улсад баримтлах стратеги, 2013 оны 6-р сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар баталсан, < <http://www.ebrd.com/downloads/country/strategy/mongolia.pdf> > (2014 оны 10-р сарын 21).

⁴¹ Мөн тэнд, хуудас 5-6.

⁴² Мүүдис агентлагийн веб хуудас, “Ration Action: Мүүдис Монголиан Ресурс компанид анх удаа ‘ВЗ’ төлөв байдал тогтвортой гэсэн үнэлгээ өгөв”, 2012 оны 10-р сарын 8, < https://www.moody.com/research/Moodys-assigns-first-time-V3-to-Mongolian-Resources-outlook-stable--PR_256966 > (2014 оны 10-р сарын 21); Ройтерс агентлагийн веб хуудас, “ТЕХТ-S&P Монголиан Ресурс Корпорэйшн-д ‘В-’; төлөв байдал тогтвортой гэсэн үнэлгээ өгөв”, 2012 оны 10-р сарын 8, < <http://www.reuters.com/article/2012/10/08/idUSWLA441720121008> > (2014 оны 10-р сарын 21).

⁴³ Мүүдис агентлагийн веб хуудас, “Ration Action: Мүүдис Монголиан Ресурс компанид анх удаа ‘ВЗ’ төлөв байдал тогтвортой гэсэн үнэлгээ өгөв”, 2012 оны 10-р сарын 8, < https://www.moody.com/research/Moodys-assigns-first-time-V3-to-Mongolian-Resources-outlook-stable--PR_256966 > (2014 оны 10-р сарын 21).

Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл – Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

компанийн нийт өрийн 50-иас илүү хувийг эзэлж байгаа тухай “Стандарт энд Пуур” дурджээ.⁴⁴ Үүнээс гадна “Эм Эр Си” нь 2012 оны 3 болон 5-р саруудад Монголын Голомт Банкид төлөх өрөө хугацаандаа төлж чадаагүй байна. Компанийн дотоод хяналт, санхүүгийн сахилга бат хангалтгүй гэж “Стандарт энд Пуур” дүгнэжээ.

Компанийн санхүүгийн байдал тааруу, мөн төмрийн хүдрийн үнэ бага байсантай холбоотойгоор компани дахин санхүүжилт авах замаар өмнө авсан зээлээ эргэн төлж чадахгүй байх гэсэн болгоомжлолын үүднээс 2013 оны эхэнд “Мүүдис” нь “Эм Эр Си”-гийн үнэлгээг бууруулжээ.⁴⁵ Рейтинг үргэлжлүүлж хийхэд хангалттай, эсвэл зохих мэдээлэлгүй байна гэж үзсэн тул хожим нь “Мүүдис” өгсөн үнэлгээнээсээ татгалзжээ.

3.3 Бизнесийн стратеги

Компанийн албан ёсны цахим хуудас дээр дурдсанчлан, “Алтайн Хүдэр” компанийн зорилт нь ‘Монголд болон бүс нутагтаа үйлдвэрлэлийн чанар, мөн экспортын хэмжээгээрээ төмрийн хүдэр олборлох, боловсруулах тэргүүлэгч компани болох’-од оршиж байна.⁴⁶

3.3.1 Өрсөлдөөний орчин

Монголд нийт 1,250 сая тонн тооцоолсон нөөц бүхий есөн төмрийн хүдрийн төсөл хэрэгжиж байна.⁴⁷ “Алтайн Хүдэр” компани одоогоор Монголд “Болдтөмөр Ерөө Гол”-ын дараа орох хоёрдахь том төмрийн хүдэр үйлдвэрлэгч компани юм. “Болдтөмөр Ерөө Гол” компани 2011 онд зах зээлийн 50-иас дээш хувь эзэлж байсан бол 2023 онд олборлолтоо дуусгахаар төлөвлөжээ.⁴⁸ “Алтайн Хүдэр” компанийн зүгээс мэдээлж байгаагаар компани одоогоор зах зээлийн 33 хувийг эзэлдэг.⁴⁹ Үүнээс гадна зах зээлийн 5-аас доош хувь эзэлдэг бусад олон компани Монголд байдаг. Бразилд төвтэй Вэйл, мөн Австралид төвтэй Рио Тинто дэлхийд хамгийн том төмрийн хүдэр үйлдвэрлэгч компаниуд юм.

Тээвэрлэлтийн зардал

Монголд бүртгэлтэй төмрийн хүдэр олборлогч хийгээд экспортлогч компани болох “Алтайн Хүдэр” нь Хятадын гангийн үйлдвэрүүдийн төмрийн хүдрийн эрэлтийг хангаж байна. Төмрийн хүдэр олборлогч уул уурхайн компаниудын хувьд тээвэрлэлтийн зардал үйл ажиллагааны зардлынх нь ихээхэн хувийг эзэлж байдаг. Монгол орон Хятадтай хил залгадаг тул Австрали, Бразил зэрэг төмрийн хүдэр үйлдвэрлэгч бусад орнуудад олборлолт хийдэг уул уурхайн компаниудтай харьцуулбал Монголд тээвэрлэлтийн зардал бага байдаг. “Волл Стрийт Журнал”-д гарсан нийтлэлд Монголоос төмрийн хүдрийн баяжмал тээвэрлэх зардал Австралиас тээвэрлэх зардлаас даруй тал хувиар бага байна гэж бичжээ.⁵⁰

⁴⁴ Ройтерс агентлагийн веб хуудас, “TEXT-S&P Монголиан Ресурс Корпорэйшн-д ‘В-’ төлөв байдал тогтвортой” гэсэн үнэлгээ өгөв”, 2012 оны 10-р сарын 8, < <http://www.reuters.com/article/2012/10/08/idUSWLA441720121008>> 2014 оны 10-р сарын 21.

⁴⁵ Мүүдис агентлагийн веб хуудас, “Rating Action: Мүүдис Монголиан Ресурс-д өгсөн үнэлгээгээ бууруулав; рейтингийг цуцлах”, 2013 оны 8-р сарын 30, < https://www.moodys.com/research/Moodys-downgrades-Mongolian-Resources-rating-to-be-withdrawn--PR_281307> 2014 оны 10-р сарын 21.

⁴⁶ “Алтайн Хүдэр” компанийн веб хуудас, Бидний тухай, “Компанийн эрхэм зорилго”, огноогүй, < <http://www.altainkhuder.mn/content/25.html>> (2014 оны 10-р сарын 21).

⁴⁷ Монголиан Майнинг Журнал, “Монголын төмрийн хүдрийн салбарын эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ” 2014 оны 3-р сар, [eri.mn/research/ERI/ERI_Iron_Ore.pdf](http://www.eri.mn/research/ERI/ERI_Iron_Ore.pdf), 2014 оны 10-р сарын 17, хуудас 1.

⁴⁸ Мөн тэнд, хуудас 9.

⁴⁹ “Эм Ар Си” Монголиан Ресурс Корпорэйшн, “Майнс энд Мани Хонгонг 2014” олон улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын үзэсгэлэнгийн үеэр танилцуулсан powerpoint танилцуулга, 2014, 2014 оны 3-р сарын 25-27, < http://www.minesandmoney.com/hongkong/wp-content/uploads/2014/04/26Mar_S2_1230_Javkhanbazar-Radnaabazar_Mongolian-Resource-Corp.pdf> (2014 оны 10-р сарын 21).

⁵⁰ “Волл Стрийт Журнал”-ын веб хуудас, “Майнголиа IPO хийхээр чармайж байна”, Блог, 2012 оны 5-р сарын 22, < <http://blogs.wsj.com/deals/2012/05/22/minegolia-struggles-with-ipos/>> 2014 оны 10-р сарын 21. Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл – Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

“Алтайн Хүдэр” компанийн борлуулалтын менежертэй хийсэн огноогүй ярилцлагад дурдсанчлан, Хятадын Баруун хойд нутагт төмрийн хүдрийн зах зээлийн өрсөлдөөн бага байдаг тул Хятадын ган үйлдвэрлэгч цөөн тооны томоохон компаниуд үндсэндээ үнэ тогтоож байдаг.⁵¹ Компанийн тухай хамгийн сүүлийн танилцуулгад дурдсан хэрэглэгчид нь гол төлөв Хятадын том гангийн үйлдвэрүүд байна.⁵² Эдгээр том компаниуд төмрийн хүдрийн компаниудын үнийг буулгах, жижиг болон дунд хэмжээний гангийн үйлдвэрүүдийг зах зээлээс шахах зорилгоор үгсэн хуйвалддаг гэж “Алтайн Хүдэр” компани дурдаж байв.⁵³

Зах зээлийн үнийн огцом уналт

2014 он гарсаар төмрийн хүдрийн зах зээлийн үнэ их хэмжээгээр буурсантай холбоотойгоор “Алтайн Хүдэр” компани ихээхэн хүндрэлтэй тулгарсан. 2013 оны 8 дугаар сараас хойш Хятадад үл хөдлөх хөрөнгийн зах зээл суларсантай голдуу холбоотойгоор төмрийн хүдрийн зах зээлийн үнэ 33 гаруй хувиар унасан.⁵⁴ Блүүмберг агентлагийн мэдээлснээр Хятадад ашиглалтад орсон, мөн зарагдсан шинэ барилгын тоо 18 хувиар буурсан тул гангийн болон ган үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийн хэрэгцээ буурсан. Хятадад төмрийн хүдрийн үнэ унасантай холбоотойгоор төмрийн хүдэр олборлодог Монголын хоёр жижиг компани үйл ажиллагаагаа нэгэнт зогсоожээ.⁵⁵ Үнийн энэ уналт “Алтайн Хүдэр” компанид хэрхэн нөлөөлсөн нь тодорхойгүй байна, гэхдээ үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн бүтэц, мөн компанийн ашигт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн нь гарцаагүй. Төмрийн хүдрийн үнэ унаснаас болж 2014 оны 8 дугаар сарын байдлаар Таян нуурын уурхай хүчин чадлынхаа 30 хувьд олборлолт хийсэн гэх мэдээ байна.⁵⁶

Хятадад төмрийн хүдрийн эрэлт хэрэгцээ унасан энэхүү байдал нь өөрийн активтай харьцуулбал их хэмжээний зээлийн үлдэгдэлтэй гэж тайлагнасан Хятадын гангийн олон үйлдвэрүүдийн санхүүгийн хүнд байдалтай шууд холбоотой.⁵⁷ “Алтайн Хүдэр” компанийн хамгийн том хэрэглэгч болох “Бауи Айрон энд Стиил Ко.” (Baui Iron & Steel Co.) нийт активын хэмжээнд эзлэх өрийн хэмжээ 86.46 хувь эзэлж байна гэж тайлагнасан бөгөөд уг компани, мөн Хятадын бусад олон гангийн үйлдвэрүүдэд тулгараад байгаа санхүүгийн хүндрэлийн улмаас үйлдвэрлэлийнхээ хэмжээг бууруулах, эсвэл үйлдвэрлэлээ түр зогсоож магадгүй гэж шинжээчид үзэж байна.

Хятадын эрэлт хэрэгцээ буурч байгаагаас гадна ган үйлдвэрлэгч дэлхийн хамгийн том хоёр орон болох Австрали болон Бразилд гангийн үйлдвэрлэл нэмэгдэж байгаа нь төмрийн хүдрийн үнэд мөн адил нөлөөлж байна. Жишээ нь, төмрийн хүдрийн үнэ унаснаас болж Хятадын өртөг өндөртэй үйлдвэрүүд үүд хаалгаа барихад хүрч байгаа тул зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх зорилгоор төмрийн хүдрийн олборлолтоо нэмэгдүүлсэн тухай саяхан “Би Эйч Пи Биллитон”-оос мэдэгдсэн.⁵⁸ 2018 он гэхэд гангийн нийлүүлэлт 45 хувиар өсөх

⁵¹ “Ажизн Метал” веб хуудас, “Монголын Алтайн Хүдэр ХХК-ийн борлуулалтын албаны дарга Хулантай хийсэн ярилцлага”, огноогүй, http://www.asianmetal.com/metal_cron/index_junshi_khulan_en.shtml (2014 оны 10-р сарын 21).

⁵² “Эм Ар Си” Монголиан Ресурс Корпорэйшн, “Майнс энд Мани Хонгонг 2014” олон улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын үзэсгэлэнгийн үеэр танилцуулсан powerpoint танилцуулга, 2014 оны 3-р сарын 25-27, < http://www.minesandmoney.com/hongkong/wp-content/uploads/2014/04/26Mar_S2_1230_Javkhanbazar-Radnaabazar_Mongolian-Resource-Corp.pdf> (2014 оны 10-р сарын 21).

⁵³ “Ажизн Метал” веб хуудас, “Монголын Алтайн Хүдэр ХХК-ийн борлуулалтын албаны дарга Хулантай хийсэн ярилцлага”, огноогүй, < http://www.asianmetal.com/metal_cron/index_junshi_khulan_en.shtml> (2014 оны 10-р сарын 21).

⁵⁴ Блүүмберг Интеллиженс, Төмрийн хүдрийн цаасны зах зээл, Блүүмбергийн мэдээллийн сангаар дамжуулан хандав.

⁵⁵ Монголиан Майнинг Журнал, “Монголын төмрийн хүдрийн салбарын эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ”, 2014 оны 3-р сар, < eri.mn/research/ERI_Iron_Ore.pdf> (2014 оны 10-р сарын 17), хуудас 2.

⁵⁶ Цээл сумын Засаг даргатай хийсэн ярилцлага, 2014 оны 8-р сарын 13.

⁵⁷ “Пийпл Дэйли” веб хуудас, “Өр овоорч гангийн үйлдвэрүүдэд хүндээр тусч байна”, 2014 оны 9-р сарын 7, < <http://english.peopledaily.com.cn/business/n/2014/0907/c90778-8779605.html>> (2014 оны 10-р сарын 21).

⁵⁸ ABC ТВ-ийн веб хуудас, “BHP төмрийн хүдрийн үйлдвэрлэл нэмэгдсэн тухай мэдээллээ”, 2014 оны 10-р сарын 22, < <http://www.abc.net.au/news/2014-10-22/bhp-posts-increase-in-iron-ore-output/5832198>> (2014 оны 10-р сарын 25).

магадлал байгааг математик загвараар тооцоолсон байна.⁵⁹

Үнийн хэлбэлзэл ба үнийн спекуляц

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр төмрийн хүдрийн үнэ маш хэлбэлзэл ихтэй байсан. Төмрийн хүдрийн бодит нийлүүлэлтээр баталгаажуулахгүй төмрийн хүдэр худалдах худалдан авах гэрээ контрактуудыг сүүлийн хэдэн жил ихээр хийх болсон төдийгүй фьючерс, дериватив зэрэг санхүүгийн бусад хэрэгслүүдийн спекуляцийн улмаас зах зээл дээр арилжаалагддаг металлууд дотроос төмрийн хүдэр хамгийн ихээр өртсөн. Огт байхгүй түүхий эдийг барьцаалан Хятадын компаниудад зээл олгосон саяхны дуулиант хэргийн улмаас төмрийн хүдрийн зах зээлийн үнэ савлахад маш ихээр нөлөөлсөн.⁶⁰

3.3.2 Өрсөлдөх чадвар

Төмрийн хүдэр олборлодог уул уурхайн бусад компанитай нэгэн адил уурхайн байршил, төмрийн хүдрийн нөөцийн хэмжээ нь “Алтайн Хүдэр” компанийн өрсөлдөх чадварыг голлон тодорхойлж байна.

Хэрэглэгчдэд ойрхон байршил нь тээвэрлэлтийн өртгийг өрсөлдөхүйц болгож байна

Бусад өрсөлдөгчидтэй харьцуулбал “Алтайн Хүдэр” компани цорын ганц буюу хамгийн том өрсөлдөх давуу талтай, энэ нь уурхайн газарзүйн байршил юм. Хятадын хилээс зөвхөн 168 км-ийн зайд байрладаг уурхай Хятадын Баруун хойд нутгийн гангийн үйлдвэрүүдийн хувьд хамгийн их сонирхол татахуйц нийлүүлэгч нь юм, учир нь далайн тээвэрлэлттэй харьцуулбал энэ бүс нутагт тээвэрлэлтийн зардал өндөр байдаг юм. Монгол дахь бусад өрсөлдөгчидтэй харьцуулбал “Алтайн Хүдэр” компанийн уурхай зах зээлдээ хамгийн ойр байрладаг тул тээвэрлэлтийн өртөг нь хамгийн бага байдаг.⁶¹ Газарзүйн байршлын хувьд энэхүү давуу байдал нь өртөг багатай төмрийн хүдэр нийлүүлэх боломжийг “Алтайн Хүдэр”-д олгож байна. “Мүүдис” агентлагаас мэдээлснээр төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэх өртөг 2011 онд нэг тонн тутамд 45 ам.доллар байсан.⁶²

Энэхүү өрсөлдөх давуу талаа зөв ашиглахын тулд компани үйлдвэрлэлийн болон тээвэрлэлтийн өртөгөө аль болох бага түвшинд барьж байх хэрэгтэй. Одоогоор “Алтайн Хүдэр” компани уурхайгаасаа Хятадын хил хүртэл хатуу хучилттай зам тавьж байгаа бөгөөд ингэснээр тээвэрлэлтийн зардлаа 25 хувиар бууруулна гэж тооцоолж байна.⁶³ Уг замыг барих, мөн ашиглах явцад байгаль орчин, нийгмийн нэлээдгүй сөрөг нөлөөлөл гарахаар байгаа ба эдгээр нөлөөллийн талаар дараахь бүлэгт дэлгэрэнгүй өгүүлнэ. Бусад өрсөлдөгчидтэй харьцуулбал “Алтайн Хүдэр” компани харьцангуй сайн чанарын төмрийн хүдэр нийлүүлдэг. Компанийн мэдээлснээр нийт ордын нөөц 38 хувийн төмрийн агууламжтайн сацуу баяжмалын агууламж нь 60-64 хувьтай байна.⁶⁴ Эдгээр үзүүлэлт нь

⁵⁹ Блүүмберг Интеллиженс, Төмрийн хүдрийн зах зээл, Блүүмбэргийн мэдээллийн сангаар дамжуулан хандав.

⁶⁰ “Си Эн Би СИ” ТВ-ийн веб хуудас, “Хятад төмрийн хүдрийн импортын зээлийг хязгаарлахаар төлөвлөж байна”, 2014 оны 4-р сарын 30, < <http://www.cnbc.com/id/101630942> > (2014 оны 10-р сарын 21).

⁶¹ Монголиан Майнинг Журнал, “Монголын төмрийн хүдрийн салбарын эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ”, 014 оны 3-р сар, < erl.mn/research/ERI/ERI_Iron_Ore.pdf > (2014 оны 10-р сарын 17), хуудас 2.

⁶² Мүүдис агентлагийн веб хуудас, “Ration Action: Мүүдис Монголиан Ресурс компанид анх удаа ‘B3’ төлөв байдал тогтвортой гэсэн үнэлгээ өгөв”, 2012 оны 10-р сарын 8 < https://www.moody's.com/research/Moodys-assigns-first-time-B3-to-Mongolian-Resources-outlook-stable--PR_256966 > (2014 оны 10-р сарын 21). Энэ тайлангийн төсөлд санал өгөхдөө US\$ 45/тонн гэсэн тоо хуучирсан гэж “Алтайн Хүдэр”-ийн зүгээс мэдэгдсэн. Гэвч компанийн үйлдвэрлэлийн өртөгтэй холбоотой сүүлийн үеийн мэдээлэл олдоогүй.

⁶³ “Эм Ар Си” Монголиан Ресурс Корпорэйшн, “Майнс энд Мани Хонгонг 2014” олон улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын үзэсгэлэнгийн үеэр танилцуулсан powerpoint танилцуулга, 2014 оны 3-р сарын 25-27, < http://www.minesandmoney.com/hongkong/wp-content/uploads/2014/04/26Mar_S2_1230_Javkhanbazar-Radnaabazar_Mongolian-Resource-Corp.pdf > (2014 оны 10-р сарын 21).

⁶⁴ Мөн тэнд.

дэлхийн зах зээл дээр дундаж үзүүлэлтэд тооцогдох боловч “Мүүдис” агентлагийн үзэж байгаагаар төмрийн агууламжаараа Азийн бусад өрсөлдөгчдийн дунд дээгүүрт орж байна.⁶⁵ Түүнчлэн Монголын бусад өрсөлдөгч компаниудын ихэнх нь шороон хүдэр нийлүүлдэг бол “Алтайн Хүдэр” төмрийн хүдрийн баяжмал нийлүүлдгээрээ бусдаас давуу талтай гэж компанийн зүгээс онцолж байна.⁶⁶ Компанийн уурхайн сайт дээрээ төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэдэг хэд хэдэн баяжуулах үйлдвэртэй. Бүлэг 4-т өгүүлсэнчлэн, эдгээр баяжуулах үйлдвэрүүдээс болж Цээл сумын ойр орчинд маш их тоосжилт үүсдэг хэмээн Цээл сумын засаг захиргааныхан хэлж байсан.

Үйлдвэрлэлийн хэмжээг огцом нэмэгдүүлэх төлөвлөгөө ба уурхайн богино нас

Эцэст нь компани ирэх хэдэн жилийн хугацаанд үйлдвэрлэлээ огцом нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. 2013 онд 2,2 сая тонн төмрийн хүдэр үйлдвэрлэсэн бол 2014 онд үйлдвэрлэлийн хэмжээгээ 3,5 сая тонн хүртэл нэмэгдүүлэхээр төлөвлөжээ.⁶⁷ Гэвч 2012 онд “Стандард энд Пуур” агентлаг төлөвлөсөн үйлдвэрлэлийн хэмжээ ‘түрэмгий’ хийгээд ‘туршигдаагүй’ тул өндөр эрсдэлтэй хэмээн дүгнэжээ.⁶⁸ Зээлээ эргэн төлөхийн тулд компани төмрийн хүдрийн үйлдвэрлэл болон борлуулалтаа нэмэгдүүлэх хэрэгтэй болно, гэвч борлуулалтаа нэмэгдүүлснээс үл хамааран компани их хэмжээний зээлийн дарамттай байсаар байх болно гэж “Стандард энд Пуур” таамагласан байна. Үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд олборлолтоо нэмэх шаардлагатай болно, улмаар тоосжилт, усны хэрэглээ, тээвэрлэлт нэмэгдэж, уурхайн талбай өргөжих нь гарцаагүй. Энэ бүгд нь нүүдэлчин малчдын амьжиргаанд улам их нөлөөлөх бий болгох магадлалтай.

Хэрэв ойрын ирээдүйд төмрийн хүдрийн үнэ өсвөл борлуулалтын зорилтууддаа хүрэх, зээлээ төлөхийн тулд “Алтайн Хүдэр” компани төмрийн хүдрийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх нь гарцаагүй.

Ирэх хэдэн жилд компани үйлдвэрлэлийнхээ хэмжээг төлөвлөсний дагуу нэмэгдүүлбэл 10 жил хүрэхгүй хугацаанд Таян нуурын уурхайн нөөц дуусна гэж “Мүүдис” тооцоолж байна.⁶⁹ Харьцуулбал, дэлхийн бараг бүх том төмрийн хүдрийн уурхайнуудын ашиглалтын хугацаа 30-аас дээш жил байна (Хүснэгт 1-ээс үзнэ үү).⁷⁰ Төмрийн хүдрийн хязгаарлагдмал нөөц, мөн үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмэгдүүлэх гэсэн компанийн стратегиас дүгнэхэд компани Цээл суманд удаан хугацаанд үйл ажиллагаа явуулах боломж бага харагдаж байна. Энэ нь сонирхогч талуудын оролцоог бодитойгоор хангах, орон нутгийн иргэдтэй хөршийн харилцааг бий болгох хөшүүрэг бүрдүүлэхэд хүндрэл үүсгэх магадлалтай.

⁶⁵ Seeking Alpha веб хуудас, “Төмрийн хүдэрт хөрөнгө оруулалт хийхэд анхаарах чухал хүчин зүйлс”, 2011 оны 4-р сарын 10, < <http://seekingalpha.com/article/262764-the-important-factors-to-consider-when-investing-in-iron-ore>> 2014 оны 10-р сарын 21; Мүүдис агентлагийн веб хуудас, “Ration Action: Мүүдис Монголиан Ресурс компанид анх удаа ‘B3’ төлөв байдал тогтвортой гэсэн үнэлгээ өгөв”, 2012 оны 10-р сарын 8, < https://www.moody.com/research/Moody-assigns-first-time-B3-to-Mongolian-Resources-outlook-stable--PR_256966> (2014 оны 10-р сарын 21).

⁶⁶ “Эм Ар Си” Монголиан Ресурс Корпорэйшн, “Майнс энд Мани Хонгонг 2014” олон улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын үзэсгэлэнгийн үеэр танилцуулсан powerpoint танилцуулга, 2014 оны 3-р сарын 25-27 < http://www.minesandmoney.com/hongkong/wp-content/uploads/2014/04/26Mar_S2_1230_Javkhanbazar-Radnaabazar_Mongolian-Resource-Corp.pdf> (2014 оны 10-р сарын 21).

⁶⁷ Мөн тэнд.

⁶⁸ Ройтерс агентлагийн веб хуудас, “TEXT-S&P Монголиан Ресурс Корпорэйшн-д ‘B-’ төлөв байдал тогтвортой гэсэн үнэлгээ өгөв”, 2012 оны 10-р сарын 8, < <http://www.reuters.com/article/2012/10/08/idUSWLA441720121008>> 2014 оны 10-р сарын 21.

⁶⁹ Мүүдис агентлагийн веб хуудас, “Ration Action: Мүүдис Монголиан Ресурс компанид анх удаа ‘B3’ төлөв байдал тогтвортой гэсэн үнэлгээ өгөв”, 2012 оны 10-р сарын 8, < https://www.moody.com/research/Moody-assigns-first-time-B3-to-Mongolian-Resources-outlook-stable--PR_256966> (2014 оны 10-р сарын 21).

⁷⁰ Mining-Technology.com веб хуудас, “Дэлхийн хамгийн том төмрийн хүдрийн уурхайнууд”, 2014 оны 2-р сарын 19 < <http://www.mining-technology.com/features/featurethe-worlds-11-biggest-iron-ore-mines-4180663/>> (2014 оны 10-р сарын 21).

Хүснэгт 1: Таян Нуур болон дэлхийн зарим төмрийн хүдрийн уурхайнуудын ашиглалтын хугацаа

Уурхай	Улс	Уурхайн хүлээгдэж буй (үлдсэн) ашиглалтын хугацаа (жилээр)
Таян Нуур	Монгол	10
Каражас	Бразил	51
Самарко Алегира	Бразил	39
Минас Итабиритос	Бразил	33
Варгем Грандэ	Бразил	44
Занага	Конгын Бүгд Найрамдах Улс	30
Симандоу	Гвинеа	30
Сишен	Өмнөд Африк	18+

Эх сурвалж: Mining-Technology.com ⁷¹

⁷¹ Mining-Technology.com веб хуудас, “Дэлхийн хам том төмрийн хүдрийн уурхайнууд”, 2014 оны 2-р сарын 19, <
<http://www.mining-technology.com/features/featurethe-worlds-11-biggest-iron-ore-mines-4180663/>> (2014 оны 10-р сарын 21).

Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл – Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

4 Таян нуурын уурхайн нөлөөлөл

Энэхүү бүлгийг “Төв болон Зүүн Европын Банкны хяналт Сүлжээ”, “Оюу Толгойн Хяналт” ТББ, “Үндэстэн дамнасан корпорацуудын судалгааны төв” байгууллагуудын Баримтжуулах хамтарсан судалгааны тайлангаас авсан хэсгүүдэд үндэслэн бичив. Уг тайланд 2014 оны 8 дугаар сард судалгааны баг Цээл сум, мөн сумын ойр орчмын нутагт очиж газар дээр нь олж тогтоосон зүйлийг тусгасан билээ. Газар дээр хийсэн судалгааны үр дүнд тогтоосон нөлөөлөл бүрийн тухай Монголын төмрийн хүдэр олборлох салбар (Бүлэг 2) болон “Алтайн Хүдэр” компанийн бизнесийн стратегийн (Бүлэг 3) онцлогтой уялдуулж өгүүлсэн.

Судалгааны үр дүнд дараахь гол зүйлийг олж тогтоосон, тухайлбал:

- Уурхайгаас Хятадын хил хүртэлх хатуу хучилттай зам барилгын болон ашиглалттай холбоотой асуудлууд нь бага өртөгтэй төмрийн хүдэр нийлүүлэгч компани болох гэсэн компанийн стратегитэй холбоотой байна;
- Уурхайн нөлөөллийн бүс дэх малчдыг албадан нүүлгэхтэй холбоотой асуудлууд, үйлдвэрлэлийн хэмжээгээ огцом нэмэгдүүлэх гэсэн компанийн түрэмгий төлөвлөгөөтэй холбоотойгоор эдгээр асуудлууд хурцдаж болох юм;
- Сонирхогч талуудын оролцоо хангалтгүй байна, үүнийг уурхайн ашиглалтын хугацаа богино гэдгээр тайлбарлаж болох юм.

Энэ бүлэгт дурдагдсан нэлээдгүй нөлөөллийн талаар өмнө хийсэн үнэлгээний тайлангуудад цохон дурдсан байдаг. Таян нуурын уурхайн Байгаль орчин, нийгмийн үнэлэлт дүгнэлт ба Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зорилгоор “Алтайн Хүдэр” компани зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “И Ар Эм” (ERM) компанитай 2011 онд гэрээ байгуулсан.⁷² Үйл ажиллагааны төлөвлөгөөнд уурхайн олборлолтоос гарч буй сөрөг нөлөөллийг бууруулах, Таян нуурын төслийн үйл ажиллагааг ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогын Гүйцэтгэлийн Шаардлагуудад нийцүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх шаардлагатай нэлээдгүй арга хэмжээнүүдийг тодорхой заажээ. Баримтжуулах судалгааны баг 2014 оны 8 дугаар сард орон нутагт ажиллахдаа эдгээр арга хэмжээнүүдээс авч хэрэгжүүлсэн эсэхэд мөн үнэлгээ хийсэн юм.

4.1 Авто замын нөлөөлөл: тоосжилтоос үүдэлтэй бохирдол болон мал, хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл

“Алтайн Хүдэр” компани Цээл сумын нутаг дэвсгэр дээр оршдог уурхайгаасаа ойролцоогоор 168 км-т алслагдсан Бургастайн хилийн боомтоор Хятад руу төмрийн хүдэр гарган экспортлож байна.⁷³ Төмрийн хүдэр тээвэрлэдэг зам нь тоосжилт ихтэй хайрган зам бөгөөд төмрийн хүдэр тээвэрлэдэг хүнд даацын машинуудаас дуу чимээ их гардаг байна. Одоогоор компани хатуу хучилттай зам тавьж байгаа бөгөөд ингэснээр Хятад руу төмрийн хүдэр

⁷² “И Ар Эм”, Байгаль орчин, нийгмийн үнэлэлт дүгнэлт ба Үйл ажиллагааны төлөвлөгөө; Таян нуурын төмрийн хүдрийн уурхай, Говь-Алтай аймаг, Монгол Улс, 2011 оны 12-р сарын 13.

⁷³ “Эм Ар Си” Монголиан Ресурс Корпорэйшн, “Майнс энд Мани Хонгонг 2014” олон улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын үзэсгэлэнгийн үеэр танилцуулсан powerpoint танилцуулга, 2014 оны 3-р сарын 25-27, < http://www.minesandmoney.com/hongkong/wp-content/uploads/2014/04/26Mar_S2_1230_Javkhlanbazar-Radnaabazar_Mongolian-Resource-Corp.pdf> (2014 оны 10-р сарын 21).

Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл – Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

тээвэрлэх цаг хожих, тээвэрлэлтийн зардал бууруулах боломж бүрдэх юм. Өмнөх бүлэгт дурдсанчлан, хатуу хучилттай зам ашиглалтад орсноор тээвэрлэлтийн зардлыг 25 хувиар бууруулна хэмээн “Алтайн Хүдэр” компани тооцоолж байна.⁷⁴

Хатуу хучилттай зам тавьснаар тоосжилт буурах, дуу чимээ багасах эерэг үр дагавар гарахын зэрэгцээ тээврийн дэд бүтэц сайжирснаар орон нутгийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлнэ хэмээн үзэж байна. Цээл сумын Засаг дарга 30 км хатуу хучилттай зам тавьж дууссан гэдгийг нотолсны зэрэгцээ замын 59 км урт бүхий хэсэг нь сумын нутаг дэвсгэр дээгүүр гарна гэж ярьсан.

Дараагийн хэсэгт баримтжуулах судалгааны үеэр уулзаж ярилцсан малчдын зүгээс төмрийн хүдэр тээвэрлэж байгаа одоогийн шороон зам, мөн шинээр барьж байгаа хатуу хучилттай замаас үүсч буй нөлөөллийн талаар хэлж ярьж байсан зүйлийг хураангуйлан өгүүлнэ. Ярилцлагад хамрагдсан малчдын ярьж байсан зүйл нь Бүлэг 2-т өгүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тайланд уул уурхайн компаниудын тээвэрлэлтийн замаас үүсч байгаа тоосжилтын улмаас хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийн талаар хийсэн дүгнэлттэй нийцэж байна.⁷⁵

Тоосжилтоос үүссэн бохирдол ба мал амьтны эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл

Судалгаа хийж байхад уулзаж ярилцсан бүх малчид, мөн Цээл сумын засаг захиргааны зарим төлөөллийн онцолж байсан гол асуудал бол гурван эх үүсвэрээс гаралтай тоосжилттой холбоотой бохирдол байсан юм, тухайлбал, уурхайгаас Хятадын хил рүү тоостой шороон замаар төмрийн хүдэр тээвэрлэж байгаа хүнд даацын машинууд; олборлолтын явцад уурхайд хийж байгаа тэсэлгээ, мөн төмрийн хүдрийг боловсруулж баяжмал үйлдвэрлэж байгаа ‘хуурай’ технологийн процесс гэсэн гурван гол эх үүсвэрээс тоосжилт үүсч байна. Төмрийн хүдрийг хилийн боомт хүртэл тээвэрлэдэг зам (уурхайгаас Хятадын хилийн боомт хүртэл) урт байгаагаас гадна малын бэлчээрийг хувааж байгаа тул малчдад хамгийн ихээр нөлөөлж байна. Нөлөөлөлд өртсөн малчдын бодит тоо тодорхой бус байгаа хэдийч уурхайн олборлолтоос шууд нөлөөлөлд өртөж байгаа малчдын тооноос хамаагүй их байх магадлалтай юм.

2011 онд “И Ар Эм” компанийн боловсруулсан Байгаль орчин, нийгмийн үнэлэлт дүгнэлт ба Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүдрийн овоолго, уурхайн ам, баяжуулах үйлдвэр болон уурхайгаас Хятадын хил хүртэл үргэлжлэх шороон зам нь ‘агаарт дээдэмхий тоос’-ны гол эх үүсвэр болж байгааг онцлон тэмдэглэсний зэрэгцээ тоосжилтыг тодорхой хэмжээнд бууруулах зорилгоор хилийн боомт хүртэл тээвэрлэлт хийж байгаа хүнд даацын машинуудад хурдны хязгаар (20 км/цаг) тогтоосон тухай дурдсан байдаг.⁷⁶ Гэвч газар дээр нь ажиглалт хийхэд энэхүү хурдны хязгаарыг компанийн жолооч нар төдийлөн дагаж мөрдөхгүй байгааг судалгааны багийнхан тогтоосон. “Алтайн Хүдэр” компаниас орчуулж өгсөн Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газраас хийсэн шалгалтын дүгнэлтэд зам дагуух зарим хяналтын цэгүүдээс авсан тоосжилтын түвшин 0.5 мг/м³ буюу зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс доогуур байна гэжээ.⁷⁷ 2013 онд хийсэн тоосжилтын хэмжилтийн үр дүн хэдий ийм гарсан боловч

⁷⁴ Мөн тэнд.

⁷⁵ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл”, Улаанбаатар хот, 2013 он, <<http://www.asiapacificforum.net/members/full-members/mongolia/downloads/annual-reports/2013>> (2014 оны 10-р сарын 17).

⁷⁶ “И Ар Эм”, Байгаль орчин, нийгмийн үнэлэлт дүгнэлт ба Үйл ажиллагааны төлөвлөгөө; Таян нуурын төмрийн хүдрийн уурхай, Говь-Алтай аймаг, Монгол Улс, 2011 оны 12-р сарын 13, хуудас 16.

⁷⁷ МУ-ын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Байгаль орчны улсын ахлах байцаагчийн дүгнэлт, “Алтайн Хүдэр” компаниас өгсөн орчуулга, 2014 оны 11-р сарын 24.

малчид тоосжилтоос үүдэлтэй бохирдол их байгаа талаар 2014 онд ч гэсэн ярьсан хэвээр байна.

Малчдын хэлж байгаагаар зам, мөн уурхайгаас гарч байгаа тоосжилтын улмаас өвс ногоо, малчдын худаг хамгийн их бохирдож байгаагаас гадна мал ихээр өвчлөх болжээ. Тээвэрлэлт хийж байгаа шороон зам дагуу, эсхүл уурхайн нөлөөллийн бүсэд өвөлжөө хаваржаа нь ойр байдаг малчдын хэлж байгаагаар Таян нуурын уурхайн олборлолт эхэлсэн тэр үеэс эхэлж мал ихээр өвчлөх болжээ. Малын хамраас ус гоожих, мал суулгахаас гадна нядалсан малын уушиг хар толботой байх нь олонтаа тохиолдох болжээ. Төрөлхийн гажигтай төл гарах, тоостой өвс ургамлаас болж амьтан мал хар өнгийн хошуутай бэлчээрээс буцаж ирдэг гэж малчид өгүүлж байв. Тоосжилтоос болж голдуу ямаа, тэмээ зэрэг хэдэн арваар тоологдох малаа алдсан тухай малчид өгүүлж байв. Хэдийгээр тоосжилтоос болж үхсэн малын тоо ихсээгүй гэж Цээл сумын захиргааны ажилтнуудын хэлж байгаа боловч цаашид тоосжилт, түүнээс үүдэлтэй бохирдлыг бууруулаагүй тохиолдолд уушигны өвчин нэмэгдэх эрсдэл байгааг тэд хүлээн зөвшөөрч байв.

Төмрийн хүдэр тээвэрлэдэг замын тоосжилтоос болж малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үүсч байгаа тухай малчдын гомдлын мөрөөр малыг нь мал эмнэлгийн болон лабораторийн хэд хэдэн удаагийн шинжилгээнд хамруулсан боловч эдгээр шинжилгээний хариу өөр өөр гарчээ. Дэрстэй багийн нэлээн хэдэн малчны хэлж байгаагаар тэдгээрийн малыг “Цээл сумын нутгийн зөвлөл”-ийн санаачилгаар нэг удаа, “Алтайн Хүдэр” компанийн санаачилгаар дор хаяж хоёр удаа шинжилгээнд хамруулсан байна.⁷⁸ Малчдын хэлж байгаагаар компанийн үйл ажиллагаанаас шууд хамааралтайгаар мал үхсэн гэдэг нь нотлогдвол “Алтайн Хүдэр” компани малчдад нөхөн олговор олгохыг хүлээн зөвшөөрсөн байна. Эхний шинжилгээний хариуг сонинд нийтэлсэн ба тоосжилт, түүнээс үүдэлтэй бохирдлын улмаас малын уушиг өвчилсөн гэдэг нь шинжилгээний хариугаар нотлогджээ. Компани шинжилгээний хариуг үл зөвшөөрч шинжилгээ хийсэн лабораторийн шинжилгээний арга барилд дүгнэлт гаргуулахаар Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнд хандсан бөгөөд шинжилгээ хийхэд хэд хэдэн алдаа, дутагдал гаргасан тухай Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс компанид өгсөн захидалд дурдсан байна.⁷⁹

2013 онд компанийн санаачилгаар Улаанбаатар хотод Мал эмнэлгийн хүрээлэнгээр Баянгол багийн малчдын бог малд хийсэн шинжилгээнд тоосжилтоос болж мал үхэх аюултай өвчин гараагүй гэж дүгнэжээ.⁸⁰

Малчдын хэлж байгаагаар компанийн санаачилгаар хийсэн шинжилгээний хариуг малчдад огт хэлээгүй байна. Тоосжилтоос болж мал үхсэн гэдгийг лабораторийн ажилтан утсаар ярихдаа албан бусаар хүлээн зөвшөөрсөн гэж нэг малчин хэлж байв. Шинжилгээний хариуг өгөх тухай малчдын хүсэлтэд “Алтайн Хүдэр” компани нэг ч удаа албан ёсны хариулт өгөөгүйн зэрэгцээ үхсэн малын нөхөн олговрыг малчдад огт өгөөгүй байна. Шинжилгээний хариуг сумын засаг захиргаанд улирал тутам өгдөгөөс гадна шинжилгээний хариутай танилцах хүсэлтийг малчдаас огт авч байгаагүй хэмээн компанийн зүгээс энэхүү тайлангийн төсөлд хариу болгож мэдэгдсэн.

Хэдийгээр мал амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэл байгаа ч гэсэн малчид тоосжилт ихтэй бэлчээрт малаа бэлчээсэн хэвээр байна. Говь-Алтай зэрэг говийн бүс нутагт

⁷⁸ Цээл сумын нутгийн зөвлөл нь Цээл сумын уугуул иргэдийг төлөөлсөн Улаанбаатар хотод байдаг олон нийтийн байгууллага юм.

⁷⁹ Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс “Алтайн Хүдэр” компанид хүргүүлсэн захиа, 2013 оны 9-р сарын 27, “Алтайн Хүдэр” компаниас өгсөн орчуулга, 2014 оны 11-р сарын 24.

⁸⁰ “Алтайн Хүдэр” компаниас өгсөн эдгээр шинжилгээний үр дүнгийн орчуулга.

мал идээших бэлчээр хомсдолтой байдаг тул малчид бэлчээрийн сайныг дагаж тэр бүр нүүж чаддаггүй; худаг устай боловч эзэнгүй сайн бэлчээр гэж байдаггүйн зэрэгцээ бусад малчдын малаа бэлчээдэг бэлчээрийн газар руу нүүж очиход тэдгээр малчид, мөн тэдгээрийн малд хүндрэл учруулдаг байна. Мал бэлчдэггүй сул газар нь мал бэлчихэд төдийлөн тохиромжгүй газар байдаг тул ийм газар руу нүүхэд малаа зүй бусаар алдах, малчдын амьжиргааны гол эх үүсвэр болсон малын ашиг шим буурах зэрэг сөрөг үр дагавартай байдаг. Үүнээс гадна малчдын жилийн турш сэлгэн буудаг өвөлжөө хаваржааны газар нь байршил сайтай, цаг уурын хувьд хүн, малын аль алинд нь таатай байдгаас гадна малчид хэдэн үеэрээ тухайн газарт амьдарсан байдгаараа онцлогтой байдаг юм. Ямар мал маллаж байгаагаас хамаарч тухайн бэлчээрийг сонгох хэрэгтэй гэж малчид ярьж байв. Жишээлбэл, тэмээ зөвхөн тодорхой газар ургадаг ургамал иддэг тул тэр газар хэдэн үеийн турш тэмээ бэлчдэг бэлчээрийн газар болж ирсэн хэмээн нэг малчин ярьж байв.

Ярилцлагад хамрагдсан малчдын хэлж байгаагаар малчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн арьсан дээр тууралт үүсэх, байнга найтаах, синусын халдвар зэргээр өвчлөх болжээ.

Шинэ замын барилгын ажлаас үүдэлтэй нөлөөлөл

Малчид, Цээл сумын засаг захиргааныхан хатуу хучилттай зам тавьснаар замын тоосжилтын асуудлыг шийдэх бололцоотой хэмээн үзэж байна. Хэдийгээр шинэ зам малын бэлчээрийг хувааж байгаа боловч компани уг замыг барихдаа малчидтай огт зөвлөлдөөгүй, тэдгээрийн санал бодлыг сонсож, малчдын хэрэгцээг огтхон ч бодолцоогүй гэж малчид үзэж байна. Шинэ зам гарам гарцгүй баригдаж байгаа нь малчдын хувьд гол асуудал болж байна. Шинэ замын зорчих хэсэг нь харьцангуй өндөрлөгтэй тул мал гарах боломжтой, аюулгүй гарам гарцгүйгээр мал амьтан замын нөгөө талд гарч бэлчихэд саад тотгор учруулж байна. “Алтайн Хүдэр” компани мал амьтан гарахад зориулж хэд хэдэн налуу гарц хийсэн боловч эдгээр нь мал гарахад хэт огцом хэмээн зарим малчид ярьж байв. Үүнээс гадна гарам гарцгүй зам нь малчид малтайгаа өвөлжөө хаваржааны газар руу нүүхэд хүндрэл учруулдаг байна. Тухайлбал, замын нөгөө талд гарахын тулд малчид хэдэн бээр газар малаа туун тойрч гардаг тул илүү түлш зарцуулж, цаг алддагаас гадна мал амьтанд хүртэл стресс учруулдаг байна. Ялангуяа өвлийн хүйтэн улиралд энэ байдал улам хүндрэл учруулна хэмээн малчид үзэж байна.

Зам тавихад ихээхэн хэмжээний хайрга шаардлагатай байдаг бөгөөд замын ажилд шаардлагатай хайрга дайрга, элс зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалыг зам дагуух карьеруудаас олборлодог. Түүнээс гадна компани хайрга бутлах өөрийн аж ахуйтай. Эдгээр карьер нь их хэмжээний тоосжилт үүсгэж байгаагаас гадна үржил шимтэй малын бэлчээр байсан газар дээр барилгын материал олборлодог гэж ярилцлагад хамрагдсан малчид ярьж байв. Эдгээр карьерын тоо, хамрах талбай нь бэлчээрийн газар хумигдахад хүргэснээс гадна малын эрүүл мэнд, ашиг шимд мөн адил сөргөөр нөлөөлж байна.

Тоосжилтоос үүдэлтэй бохирдлын улмаас орлогоо алдах болжээ

Ярилцлагад хамрагдсан Дэрстэй багийн арван хоёр малчин өрх тоосжилт, түүний бохирдлоос болж малчдын амьжиргааны гол эх үүсвэр болсон ноос, ноолуурын чанар муудахад хүрч байгаа тухай гомдол хэлж байсан. 200 малчдыг хамруулсан орон нутгийн малчдын хоршооны даргын ярьснаар уурхайн олборлолт эхэлснээс хойш хоршооны малчдын тушаадаг ноолуурын чанар муудаж улмаар эрэлт хэрэгцээ нь буурчээ. Иргэдийн ярьж байгаагаар Хятад наймаачид уурхайн олборлолт хийж байгаа нутгийн малын ноос, ноолуурын чанарыг ялгаж салгаж чаддаг болсон тул бага үнэ хэлэх, эсвэл ноос ноолуурыг худалдан авахаас шууд татгалздаг байна.

4.2 Уурхайн нөлөөллийн бүс дэх албадан нүүлгэн шилжүүлэлт

“Алтайн Хүдэр” компанийн уурхайн төсөл хэрэгжиж эхэлсэн эхний үе шат буюу 2007-2011 оны хооронд компанийн лицензтэй талбайн ойр орчим өвөлжөөтэй байсан 22 малчин өрхийг компани нүүлгэн шилжүүлжээ. Малчид зөвхөн өвөлжөөний газар эзэмших эрхтэй байдаг бөгөөд өвөлжөөний газрын хэмжээ 0.7 га байдаг. Малчид уг газар дээрээ малын хашаа, саравч зэргийг барьдаг. Өвөлжөөний газар эзэмших эрх өвөлжөөний ойролцоох малын бэлчээрт хамаардаггүй. Таван хошуу малын төрөл, мөн цаг уурын нөхцөл байдлаас хамаарч бэлчээрийн газар 5 км-аас 30 км хүртэлх том талбай эзэлж байдаг. Уурхайн олборлолтын хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотойгоор малчдыг одоо хүртэл нүүлгэн шилжүүлж байгаа гэж нэг малчин дурдаж байсан. Урьд өмнө нүүлгэн шилжүүлсэн малчдаас гадна уурхайн олборлолт явагдаж байгаа одоогийн талбайгаас нүүхэд хүрсэн малчид байгаа бөгөөд эдгээрийн тоо тодорхойгүй байна. “Алтайн Хүдэр” компанийн нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд бэлэн мөнгөний нөхөн олговор олгохоор тусгасан байдаг боловч шинээр өвөлжөөний газар олгох тухай огт тусгагдаагүй байна.

2011 оны 12 дугаар сард батлагдсан Байгаль орчин, нийгмийн үнэлэлт дүгнэлт ба Үйл ажиллагааны төлөвлөгөөнд уурхайн лицензтэй талбайгаас малчдыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой хэд хэдэн гол ноцтой асуудал байгааг онцлон дурдаж сайжруулах зарим арга хэмжээ авахыг санал болгожээ. Үүнд:⁸¹

- өмнөх нүүлгэн шилжүүлэлт болон төлөвлөж буй биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртөх өрхүүдийн тоог төслийн талбай тус бүрээр (уурхай, ажилчдын хотхон, зам зэрэг) нарийвчлан гаргах;
- нүүлгэн шилжүүлэлтэд шууд болон шууд бусаар өртсөн малчин өрхүүдийн амьжиргаа нүүлгэн шилжүүлснээс өмнөх үетэй харьцуулбал дордоогүй, эсвэл нэмэгдсэн гэдгийг нотлох зорилгоор нүүлгэн шилжүүлэлтийн дараахь өрхийн амьжиргааны судалгаа хийх;
- хөрөнгөө алдсан малчдад олгосон нөхөн олговрын хэмжээ уг хөрөнгийг бүрэн орлуулах хэмжээгээр олгосон гэдгийг судалгаа хийж нотлох. Эдгээр арга хэмжээг 2012 оны 5 дугаар сар гэхэд хэрэгжүүлсэн байх шаардлагатай байсан ба “Алтайн Хүдэр” компанийн олон нийттэй харилцах ажилтан, мөн Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ (БОНЭМНҮ)-ний зөвлөх компани уг ажлыг хийх үүрэгтэй байсан.

Компанийн их хэмжээний өр, мөн олборлолтынхоо хэмжээг огцом нэмэгдүүлэх төлөвлөгөө, стратеги (энэ талаар Бүлэг 3-т өгүүлсэн)-тэй холбоотойгоор ирэх жилүүдэд уурхайн нөлөөллийн бүс өргөжиж улмаар нэмэлт нүүлгэн шилжүүлэлт хийх магадлал байна. Төмрийн хүдрийн үнийн өнөөгийн уналт зогсох тэр үед компани үйлдвэрлэлийнхээ төлөвлөгөөнд хүрэхийн тулд олборлолтоо эрс нэмэгдүүлэх болно. Ингэснээр малчид болон бусад холбогдох талуудад ихээхэн нөлөөлөл үзүүлэх магадлалтай байгаа тул дээр дурдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь улам чухал болж байна.

Нүүлгэн шилжүүлэх арга хэлбэрийг малчин тус бүртэй гарцаарчлан тохиролцжээ

“Алтайн Хүдэр” компани нь нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн малчдад нөхөн олговрыг шууд бэлэн мөнгөөр олгосон байна. Байгаль орчин, нийгмийн үнэлэлт дүгнэлт ба Үйл ажиллагааны төлөвлөгөөнд “газар дээрх бүх барилга байгууламж (өөрөөр хэлбэл, гэр болон малын хашаа

⁸¹ “И Ар Эм”, Байгаль орчин, нийгмийн үнэлэлт дүгнэлт ба Үйл ажиллагааны төлөвлөгөө; Таян нуурын төмрийн хүдрийн уурхай, Говь-Алтай аймаг, Монгол Улс, 2011 оны 12-р сарын 13.
Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл – Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

хороо, саравч)-ийг харилцан тохиролцсоны үндсэн дээр зах зээлийн бодит үнээр тооцож алдсан хөрөнгийн нөхөн олговорт олгох гол зарчмыг гэрээ хэлцэл хийхэд баримтална”⁸² гэж тодорхой заасан байна. Ярилцлагад хамрагдсан малчдын хэлж байгаагаар ийм төрлийн тохиролцоог малчин бүртэй ганцаарчилсан байдлаар сумын засаг захиргааны холбогдох албан тушаалтнуудыг оролцуулалгүйгээр хийжээ. Харин компанийн зүгээс нөхөн олговрын асуудлаар малчидтай ярилцан тохиролцож байхад газрын мэргэжилтэн, Засаг дарга байлцаж байсан гэж тайлбарлаж байна. Цээл сумын Засаг даргын хэлж байгаагаар сумын засаг захиргаа нүүлгэн шилжүүлэлт, түүнтэй холбоотой нөхөн олговрын асуудалтай урьд өмнө тулгарч байгаагүй тул малчидтай хийх гэрээ хэлцэл, тохиролцоонд ямар эрх үүрэгтэй оролцохоо мэдэхгүй байсан. “Алтайн Хүдэр” компани, малчид гэсэн хоёр талын хооронд хийж байгаа гэрээ хэлцэлд сумын засаг захиргаа хөндлөнгөөс оролцох эрхгүй хэмээн сумын Засаг дарга байр сууриа илэрхийлсэн. Компани болон малчид хоорондоо байгуулсан гэрээний нөхцөлийг хангуулахад сумын засаг захиргааны үүрэг оршино хэмээн тэд үзэж байгаа боловч харин хэрхэн гэрээний биелэлтийг хангуулахаа мэдэхгүй байгаагаар хэлж байв.

Орон нутгийн засаг захиргааны оролцоогүйгээр малчин тус бүртэй ганцаарчилсан гэрээ хэлцэл хийсэн тул малчид, тэгш эрхтэйгээр, мэдээлэл дээр үндэслэн гэрээ хэлцэл хийх бололцоогүй байсан. Компанийн зүгээс гэрээ хэлцэл хийж эхлэхэд өөрийн өвөлжөөний газрын үнэ цэнэ, өмчлөх эрх эдэлдэг тухайгаа огт мэдээгүй гэж нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн нэг малчин эмэгтэй хэлж байв. Тэрээр өвөлжөө өмчлөх эрхээ компанид шилжүүлэн өгөхөөс өөр сонголт байхгүй гэж бодсоны зэрэгцээ үүнээс гарах хууль эрхзүйн үр дагаврын талаар ямар ч ойлголтгүй байсан байна. Түүний гаргах шийдвэрээс үл хамааран уурхайн олборлолт явагдах тул компанийн зүгээс санал болгосон нөхөн олговрыг авах, эсхүл огт юу ч авахгүй байх гэсэн хоёрхон сонголт байна гэж тэр малчин эмэгтэй боджээ. Компанитай байгуулсан гэрээний дагуу тэрээр өөрийн газраа чөлөөлөн өгч газраасаа нүүх хэрэгтэй гэдгийг эхэндээ ойлгоогүй байна, учир нь компани түүний газрыг түр хугацаагаар ашиглах юм байна гэсэн л ойлголттой байжээ. Өвөлжөөнийхөө газрын бичгийг авчирч өг гэж компанийнхан уг малчин эмэгтэйд хэлсний дагуу тэрээр өмчлөлийн эрхийн бичгээ өгч онд нь бэлэн мөнгө авчээ. Өвөлжөөний газар нь нэлээн алсмагдмал байдаг, мөн газрыг худалдаж авдаггүй, харин иргэдийн нийтийн хурлаар ардчилсан байдлаар хуваарилдаг тул өөрт нь санал болгосон нөхөн олговрын хэмжээ хэр шударга байгаа эсэхийг малчин эмэгтэй дүгнэж цэгнэх бололцоогүй байжээ. Харин дараа нь аймгийн захиргаанд ажилладаг хамаатнаасаа түүний газрын үнэлгээ компаниас олгосон нөхөн олговрын хэмжээнээс 14 дахин их байсан гэж сонсжээ.

Нөхөн олговрыг тохирсон цаг хугацаандаа өгөхгүй эсхүл шилжүүлэхгүй байсан гэж зарим малчид ярьсан. Зарим малчид Улаанбаатар хүртэл очиж нөхөн олговор олгогдохгүй байгаа талаар гомдол гаргаж байж бэлэн мөнгөөр нөхөн олговроо авч байсан гэж сумын Засаг дарга хэлж байсан.

Бэлэн мөнгөний нөхөн олговор үр дүнтэй нөхөн олговор болж чадахгүй байна

Малчдад олгосон нөхөн олговор нь малчдын өвөлжөө хаваржааны бодит үнэ цэнэтэй дүйцэж байгаа эсэхээс үл хамааран нөхөн олговрын асуудлыг бэлэн мөнгө олгох байдлаар шийдсэн нь нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн малчдын хохирлыг барагдуулах, нүүлгэн шилжүүлэх үр дүнтэй арга хэмжээ болж огтхон ч чадахгүй. Баянгол багийн Засаг даргын тайлбарласнаар бол багийн нутаг дэвсгэр дээр байгаа бэлчээрийн сул газрыг улирал тутам хийдэг багийн нийт иргэдийн хурлаар ардчилсан байдлаар малчдад хуваарилдаг, өөрөөр хэлбэл, малчид нөхөн олговор хэлбэрээр авсан бэлэн мөнгөөрөө шинэ өвөлжөө хаваржаа

⁸² “И Ар Эм”, Байгаль орчин, нийгмийн үнэлэлт дүгнэлт ба Үйл ажиллагааны төлөвлөгөө; Таян нуурын төмрийн хүдрийн уурхай, Говь-Алтай аймаг, Монгол Улс, 2011 оны 12-р сарын 13, хуудас 22.

барих зорилгоор газар худалдан авах ямар ч бололцоогүй. Иймд бэлэн мөнгөөр нөхөн олговор олгох нь малчдад нүүж очих шинэ газраа олоход нь огтхон ч нэмэр болохгүй байна. “Алтайн Хүдэр” компанийн хэрэгжүүлж буй нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрт шинээр газар хуваарилах асуудал тусгагдаагүй тул нүүлгэн шилжүүлсэн малчид өвөлжөөгөө барих газраа одоо хэрнээ олоогүй байна. Ярилцлагад орсон малчин эмэгтэйн хэлснээр тэрээр өвөлжөөний газар хуваарилж өгөх өргөдөл гаргасан боловч компаниас нөхөн олговор авсан тул иргэдийн нийтийн эзэмшлийн газрыг компанид худалдаж байгаа хэлбэр хэмээн багийн нийт иргэдийн хурлаас үзэж малчин эмэгтэйд газар хуваарилах боломжгүй гэсэн шийдвэр гаргажээ.

“Алтайн Хүдэр” компанийн зүгээс мэдэгдэж байгаагаар сумын засаг захиргаа нүүлгэн шилжүүлсэн малчдад шинээр газар хуваарилах сонирхолгүй байгаа талаар нүүлгэн шилжүүлсэн малчид компанид хандан гомдол гаргаж байсан тул компани, Цээл сумын Засаг даргад хандаж эдгээр нүүлгэн шилжүүлсэн малчдад газар хуваарилж өгөх тухай хүсэлт гаргажээ. Гэвч Цээл сумын захиргаа нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн малчдад шинэ газар хуваарилах үүрэгтэй гэдгээ хүлээн зөвшөөрөхгүй байна. Сум нь жил бүр газрын төлөвлөлт хийж газар хуваарилдаг нийтлэг журамтай бөгөөд малчдыг өөр газар руу нүүлгэн шилжүүлэхэд хангалттай газар суманд байгаа хэмээн сумын захиргаанаас мэдэгдсэн. Гэхдээ малчид үүнтэй санал нийлэхгүй байгаа ба малаа бэлчээж болох сайн бэлчээр аль хэдийн эзэнтэй болсон хэмээн ярилцлагад хамрагдсан малчид тайлбарлаж байна. Сул газар байдаг хэдийч энэ нь мал бэлчихэд тохиромжгүй газар байдаг байна.

Дээрх байдлаас болж малчид нөхөн олголт авсан бэлэн мөнгөөрөө шинэ өвөлжөөний газар худалдан авч чадахгүй нөхцөл байдалд орсноос гадна бусад малчид бэлчээрээ ашиглуулахыг эсэргүүцэж байгаа тул эдгээр малчид өвөлжөөний газартай болох бололцоогүй болоод байна. Сумын захиргаа, компанийн аль аль нь эдгээр малчдад газар хуваарилж өгөхийн тулд ямар ч арга хэмжээ авахгүй байгаа тул малчид очих газаргүй болоод байна. Ийм нөхцөл байдлаас болж зарим малчин өрхүүд компанид чөлөөлж өгсөн хуучин өвөлжөөний газартаа нүүж очихыг оролджээ. Сумын Засаг даргын хэлсэнчлэн, “Алтайн Хүдэр” компани Засаг даргад хандаж уурхайн эзэмшлийн талбай руу буцаж нүүн орж олборлолтын үйл ажиллагаанд саад учруулсан, улмаар өөрсдийн эрүүл мэнд, аюулгүй байдлаа эрсдэлд оруулсан эдгээр малчдыг уурхайн талбайгаас гаргахад туслалцаа үзүүлэх тухай хүсэлт тавьжээ. Эдгээр нь бүгд өмнө нь нүүлгэн шилжүүлсэн малчин өрхүүд байжээ.

Оролцогч талууд нүүлгэн шилжүүлэлтийн дараахь судалгааны талаар мэдээлэлгүй байна

Нүүлгэн шилжүүлсэн малчдын амьжиргааны талаар судалгаа хийх тухай гэрээнд заасан үүргийнхээ дагуу “Алтайн Хүдэр” компани ийм төрлийн судалгаа хийдэг туршлагатай компаниар судалгаа хийлгэсэн бөгөөд уурхайн олборлолттой холбоотойгоор малчид хөрөнгөө алдаагүй хэмээн судалгааны компани дүгнэжээ. Уг компани нүүлгэн шилжүүлснээс өмнөх болон дараахь үеийн өрхийн амьжиргааны харьцуулсан судалгаа хийсэн, судалгааны үр дүнд үндэслэн нийгмийн хэд хэдэн хөтөлбөр боловсруулсан гэж “Алтайн Хүдэр” компанийн зүгээс мэдэгдсэн. Гэвч орон нутагт хийсэн судалгааны үеэр уулзаж ярилцсан нэг ч хүн ийм төрлийн судалгаа хийсэн талаар огтхон ч сонсоогүй байна. Уг судалгаа хийсэн компани Цээл сумын Засаг дарга, малчдын алинтай нь ч өрхийн амьжиргааны судалгааны асуудлаар огт уулзаагүй байна.

Нөгөөтэйгүүр, уурхайн төсөл хэрэгжиж эхэлсэн тэр үеэс эхлэн малчдын амьдралд нэлээд хэдэн ноцтой сөрөг зүйл нөлөөлөх болсон гэж ярилцлагад хамрагдсан малчид ярьж байсан. Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн нэг малчин эмэгтэйн ярьснаар бол түүний малын тоо толгой нүүхээс өмнөхтэй харьцуулбал хоёр дахин хорогдсон, тиймээс тэрээр одоо хамаатан садныхнаасаа тусламж авахад хүрсэн ба малаа хамаатныхаа бэлчээрт бэлчээдэг болжээ.

Судалгааны баг хөдөө орон нутагт ажиллаж байхад энэ эмэгтэй малчин хамаатныхаа газар дээр зусаж байсан бөгөөд хүргэнийхээ өвөлжөө рүү нүүх төлөвлөгөөтэй байсан. Гэтэл хүргэнийх нь өвөлжөө уурхайн эзэмшлийн газар дээр байгаа тул хүргэн нь мөн адил газраа чөлөөлөх болж байгаа бололтой. Малчин эмэгтэй тэр өвөлжөөний газрыг ашиглах боломжтой эсэхээ тэр бүр сайн мэдэхгүй байсан, хэрэв ашиглаж чадахгүй бол түүнд өөр ямар ч гарц алга байна.

4.3 Сонирхогч талуудын оролцоо хангалтгүй байна

Бүлэг 3-т өгүүлсэнчлэн, компани уурхайн олборлолтынхоо хэмжээг огцом нэмэгдүүлэх зорилготой байгаа бол уурхайн ашиглалтын хугацаа 10 жил хүрэхгүй байна. Иймд уурхай ашиглах богино хугацаа нь орон нутгийн иргэд, бусад сонирхогч талуудын эрхийг хүндэтгэж оролцоог нь бүрэн утгаар хангах хөшүүрэг болж чадахгүй байна.

Компанийн зүгээс мэдэгдэж байгаагаар төслийн эхний үе шатнаас эхэлж компани Цээл сумын иргэдийн оролцоог хангаж иржээ. Сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, тоосжилтыг дарах арга хэмжээнд мониторинг хийх, тоосжилт, түүнээс үүдэлтэй бохирдол, ус ашиглалтын талаарх мэдээллийг Цээл сумын иргэдэд ил тод болгох, гомдол барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгох зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийг компани хүлээсэн байна. Малчдын төлөөлөл, Цээл сумын засаг захиргаа, багийн Засаг дарга нар нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт оролцож байсан хэмээн компанийн зүгээс мэдэгдэж байна. Гэвч баримтжуулах ажлын хүрээнд сонирхогч талуудад мэдээллийг огт ил тод болгоогүйн зэрэгцээ шүүмжлэл хэлсэн малчдыг айлган сүрдүүлж дарамталж байсныг олж тогтоосон.

Мэдээллийн ил тод байдал огт алга байна

Судалгааны баг, нөлөөлөлд өртсөн иргэд, орон нутгийн засаг захиргааны холбогдох албан тушаалтнуудтай хийсэн ярилцлагууд дээрээ үндэслэн иргэд, орон нутгийн засаг захиргааны аль нь ч “Алтайн Хүдэр” компани, Таян нуурын уурхайн төсөл, түүний нөлөөллийн талаар ямар ч мэдээлэлгүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Малчид, орон нутгийн засаг захиргааныхны хэлж байгаагаар уурхайн төсөл эхлэхээс өмнө компани, ЕСБХБ, эсхүл холбогдох зөвлөхүүдийн аль нь ч төслийн талаар орон нутгийн иргэд, засаг захиргаанд мэдээлэл өгч огтхон ч зөвлөлдөөгүй байна. Цаашилбал малчид, орон нутгийн засаг захиргааныхан уурхайгаас иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ эсвэл судалгаа хийсэн талаар ямар ч мэдээлэлгүй байна. Сум болон багийн засаг захиргааныхан уурхайн нөлөөлөлд өртсөн иргэдийн эрхийг тууштай хамгаалах зохих мэдлэг, чадвар дутмаг гэдгээ хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ Таян нуурын уурхайн төсөл нь орон нутагт хэрэгжиж байгаа анхны уул уурхайн төсөл учраас компани, орон нутаг ямар үүрэг хариуцлага хүлээхээ сайтар ялгаж салгаж чадахгүй байгаа бололтой. Ярилцлагад оролцсон бүх малчид, компанийн зүгээс тоосжилт, түүнээс үүдэх бохирдол, уурхайн үйлдвэрлэлд ашиглах усны талаарх мэдээллийг хэзээ ч ил тод болгож байгаагүй гэж байна.

Баянгол, Дэрстэй багийн малчид уг уурхайн төсөлд ЕСБХБ санхүүжилт олгосон тухай сонсож байгаагүй, ЕСБХБ уг төслийг санхүүжүүлснээр нэг талаас банк, нөгөө талаас банкны зээлдэгч болох “Алтайн Хүдэр” компани тус бүр ямар үүрэг хүлээж байгаа тухай мэдээлэлгүй байна. Уг уурхайн төслийг эрх мэдэл, хөрөнгө мөнгөтэй нэг л хүний хийж байгаа бизнес гэж үзэж байгаагаар малчдын нэг бүлэг хэлж байсан бөгөөд тэр хүн байгалийн нөөцийг булаан авч, байгаль орчныг сүйтгэн, малчдыг газраас нь хөөж амьжиргаанаас нь салгаж байна гэж эдгээр малчид ярьж байв.

Айлган сүрдүүлэлт ба дарамт шахалт

“Алтайн Хүдэр” компани нь Цээл сумын иргэдийн дунд компанийн үйл ажиллагааг шүүмжилсэн иргэдийг айлган сүрдүүлдгээрээ маш муу нэртэй болжээ. Компанийн эсрэг дуугарсан гэх, үйл ажиллагааг нь ил тодоор шүүмжилж гомдол гаргасан иргэдийн эсрэг ойролцоогоор долоон гомдол гарган улмаар *‘зохион байгуулалттайгаар бусдын нэр хүндэд халдаж, гутаан доромжлох’* гэсэн үндэслэлээр эдгээр иргэдийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгүүлжээ.⁸³ Энэ нь маш ноцтой гэмт хэрэг бөгөөд Монгол Улсын эрүүгийн хуулиар 22 жил хүртэл шоронд хорих ял оноодог юм. Хоёр багийн Засаг дарга нар, эрүүл мэндийн ажилтнууд, иргэдийн төлөөлөгчдийн хурлын зарим гишүүд зэрэг компанийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандсан иргэдийг хуулийн байгууллагаар мөрдүүлж Говь-Алтай аймгийн шүүхэд хэрэгтнээр татуулсан байна. Гэмт хэргийн бүрэлдэлхүүн байхгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгоход компани анхан шатны шүүхийн шийдвэрийг эсэргүүцэн давж заалдаж, иргэдийг Улаанбаатар хот руу давж заалдах шатны шүүхэд дуудуулах зэргээр хот орох замын зардал гаргах, нэр төрд нь сэв суулгах зэргээр нэр бүхий иргэдэд хохирол учруулжээ. 2014 оны 5 дугаар сард болсон Улсын Дээд шүүх буюу хяналтын шатны шүүхээс уг хэргийг хэрэгсэхгүй болгосон. Хариуцагчаар татагдсан долоон иргэн одоогоор хилс хэрэгт холбогдуулж их хэмжээний зардал гаргасан, нэр төрийн хувьд хохирол амссан гэсэн үндэслэлээр компанийн эсрэг шүүхэд гомдол гаргахаар бэлтгэж байна.

Ярилцлагад хамрагдсан нэлээн хэдэн малчдын ярьснаар, малчид уурхайн сайтад очиж компанийн төлөөлөгчтэй уулзаж санал гомдлынхоо талаар ярилцах тухай хүсэлтээ тавихад уурхайн хамгаалалтын албаныхан тэдгээрийг айлган сүрдүүлж дотогш оруулдаггүй байна. Уурхайн сайт руу иргэд орохыг хориглох бодит шалтгаан байдаг хэдийч малчид компанийн төлөөлөлтэй уулзахад хүндрэл учирдаг гэдгийг энэ жишээ тод харуулж байна. “Цээл сумын нутгийн зөвлөл”-ийнхэн үүнтэй ижил төстэй байдалд орж байсан тухайгаа мөн ярьсан, тухайлбал, уурхайн хамгаалалтын албаныхан нэг удаа тэдгээрийн гэрэл зургийн аппарат болон үүрэн телефон утсыг нь хураан авч буцаан олгоогүй байна.

Гомдол гаргах механизм үр дүнгүй байна

“Алтайн Хүдэр” компани гомдол барагдуулах механизм бий болгох үүрэг хүлээсний дагуу Цээл сумын захиргааны байранд иргэдийн өргөдөл гомдол авах хайрцаг байрлуулжээ.⁸⁴ Үүнээс гадна компани орон нутгийн иргэдтэй харилцах нэг ажилтныг томилжээ. Гэсэн хэдийч нэг малчныг эс тооцвол бусад малчид санал хүсэлтийн хайрцагны талаар мэдэхгүй байна. Уг хайрцаг байдгийг мэднэ гэж хариулсан нэг малчин гомдлоо бичиж энэхүү хайрцагт хийсэн боловч компаниас ямар ч хариу аваагүй байна.

⁸³ “Оюу Толгойн Хяналт” ТББ, Баримтжуулалтын ажлын тайлан, Таян нуурын төмрийн хүдрийн төсөл, 2014 оны 3-р сарын 6-11, хэвлэгдээгүй тайлан.

⁸⁴ Мөн тэнд, хуудас 25.

5. Байгаль орчин, нийгмийн стандартуудын зөрчил

“Алтайн Хүдэр” компани, ЕСБХБ-ны хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу компани ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ)-ыг хангасан үйл ажиллагаа явуулах үүрэгтэй. Энэ бүлэгт байгаль орчин, нийгмийн стандартуудтай холбоотойгоор өмнөх бүлэгт өгүүлсэн “Алтайн Хүдэр”-ийн уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй гол гол нөлөөллийн талаар өгүүлэх болно.⁸⁵ ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогод дурдсанчлан, Гүйцэтгэлийн Шаардлагууд нь Банкнаас санхүүжилт авсан зээлдэгчийн хэрэгжүүлэх төслийн байгаль орчин, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах үүрэг, хариуцлагыг тодорхойлж байдаг. Товчоор хэлбэл, эдгээр Гүйцэтгэлийн Шаардлагуудад “Алтайн Хүдэр” компаниас хангаж ажиллах шаардлагатай байгаль орчин, нийгмийн менежмент (ГШ 1); орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал (ГШ 4); нүүлгэн шилжүүлэлт ба эдийн засгийн суурьшил алдалт (ГШ 5); мэдээллийн ил тод байдал ба сонирхогч талуудын оролцоо (ГШ 10) зэрэг стандартуудыг тогтоосон байдаг.

5.1 Гүйцэтгэлийн Шаардлага 1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ ба менежмент

Гүйцэтгэлийн Шаардлага 1-ийн зорилго нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийг системтэйгээр удирдах, эдгээр нөлөөлөлд тогтмол мониторинг хийхэд оршдог ба сонирхогч уг шаардлагад сонирхогч талуудын оролцоог хангахад чухал ач холбогдол өгсөн байдаг. Уг стандартыг хангахын тулд “Алтайн Хүдэр” компани холбогдох сонирхогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ зэрэг бусад үнэлгээний ажлыг хийсэн байх шаардлагатай. Ингэхдээ компани *‘хэрэгжүүлэхээр санал болгож байгаа төсөлтэй холбоотой ирээдүйд гарч болзошгүй аливаа нөлөөллийг тодорхойлж түүнд үнэлгээ хийх, нөлөөллийг бууруулах арга замуудыг тодорхойлж, эдгээр нөлөөллөөс зайлсхийх, хэрэв ингэх боломжгүй бол нөлөөллийг бууруулах, мөн арилгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг санал болгох’* зорилгоор магадлан шинжилгээ хийсэн байх шаардлагатай байдаг.⁸⁶ Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээн дээр үндэслэн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ)-г боловсруулж хэрэгжүүлэх ёстой байдаг.

Компанийн үйл ажиллагааг банкны Гүйцэтгэлийн Шаардлагуудад нийцүүлэх үүднээс байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийж үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахаар “Алтайн Хүдэр” компанийн гэрээлсэн хөндлөнгийн зөвлөх компанийн үнэлгээ хийсэн процессыг хангалтгүй гэж дүгнэжээ. “Алтайн Хүдэр”-ийн хийсэн нөлөөллийн үнэлгээ нь экологийн нөлөөллийн үнэлгээ, мэдээллийн ил тод байдал, зөвлөлдөх процессыг

⁸⁵ Энэ бүлэгт тайлангийн анхаарлын төвд байгаа тодорхой нөлөөллийн талаар Гүйцэтгэлийн Шаардлагуудын дагуу компанийн зүгээс хүлээсэн үүрэг хариуцлагад хийсэн үнэлгээг оруулсан. Баримт цуглуулах судалгааны баг бусад сөрөг нөлөөллийг газар дээр нь тогтоосон бөгөөд эдгээр нөлөөлөлд хийсэн үнэлгээ, мөн холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагуудын талаар судалгааны багийн тайлангаас олж үзэх боломжтой.

⁸⁶ ЕСБХБ, Байгаль орчин, нийгмийн бодлого, 2014 оны 5-р сар, < <http://www.ebrd.com/downloads/research/policies/esp-english.pdf>> (2014 оны 10-р сарын 21), хуудас 11. ЕСБХБ Таян нуурын уурхайн төслийг “Б” Ангиллын төсөл хэмээн ангилсан байдаг.

баримтжуулсан байдал, төслийн усны хэрэглээнээс үүсэх нөлөөлөл, мөн нийгмийн нөлөөллийн хувьд Гүйцэтгэлийн Шаардлагуудыг хангахгүй байна гэж зөвлөх компани дүгнэжээ.

Уурхайн олборлолтын улмаас нөлөөлөлд өртсөн малчид, мөн орон нутгийн засаг захиргааны зүгээс төсөл эхлэхээс өмнө ч, төсөл хэрэгжиж байгаа хугацаанд ч мөн адил уурхайн төслийн улмаас орон нутгийн иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж байгаа талаар компанийн зүгээс огтхон ч сонирхож энэ талаар иргэдтэй ярилцдаггүй гэж ярьж байна. Уурхайн нөлөөллийн талаар иргэдээс мэдээлэл огт авдаггүй, малчид, бусад сонирхогч талуудаас гаргасан санал, өргөдөл гомдлын дагуу арга хэмжээ авч улмаар компанийн гүйцэтгэлийг сайжруулах тал дээр компанийн зүгээс ямар ч арга хэмжээ авдаггүй гэж малчид онцлон хэлж байна. Харин ч эсрэгээр малчид санаа бодлоо хэлэх, эсвэл гаргасан өргөдөл гомдлынхоо дагуу компаниас арга хэмжээ авахыг хэлж шаардахад компанийн зүгээс малчдыг айлган сүрдүүлж, шахалт дарамт үзүүлдэг байна.

5.2 Гүйцэтгэлийн Шаардлага 3: Бохирдлоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах

Гүйцэтгэлийн Шаардлага 3-ын зорилго нь төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч байгаа бохирдлоос зайлсхийх, түүнийг багасгах замаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, эсвэл эдгээр нөлөөллийг бууруулахад оршдог. ЕСБХБ-наас зааж байгаагаар, *‘бохирдлоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах нь тогтвортой хөгжлийн зорилтын чухал хэсэг ба ЕСБХБ-ны санхүүжилттэй төслүүд энэ чиглэлээр олон улсын шилдэг практик, тэргүүн туршлагыг хэрэжүүлсэн байх шаардлагатай’* байдаг.⁸⁷ Энэхүү ГШ-ыг хангахын тулд “Алтайн Хүдэр” компани бохирдуулагчийг эх үүсвэр дээр нь гаргахаас зайлсхийх, хэрэв ингэх боломжгүй бол түүнийг багасгах, эсвэл бууруулах, мөн уурхайн төслөөс хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, тодорхой бус үр дагавартай хуримтлагдах нөлөөллийг харгалзан үзэх замаар байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах шаардлагатай.

“Алтайн Хүдэр” компаниас өгсөн шинжилгээний хариунаас үзэхэд, Цээл суман дахь тоосжилтын хэмжээ зөвшөөрөгдөх түвшинд байна. Гэсэн хэдийч, Бүлэг 4-т дурдсанчлан, уурхайн төслийн үйл ажиллагаанаас үүссэн тоосжилттой холбоотой бохирдол их байгаа бөгөөд бохирдол нь агаар, хөрс, ургамал, мөн мал, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа тухай ярилцлагад хамрагдсан оролцогч талууд онцолж байсан. Тоосжилтын улмаас малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үүсч байгаа тухай малчдаас гомдол гаргасны дагуу компани эдгээр малчдын малд шинжилгээ хийлгэсэн боловч шинжилгээний хариуг малчдад огт танилцуулаагүй байна. Малчид хүн болон малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл гарах вий хэмээн айдастай байдаг хэдийч тоос ихтэй бэлчээрээ ашигласан хэвээр байна. Сумын газар нутаг хагас цөлөрхөг бүсэд байрладаг тул тоосжилтоос үүдэлтэй бохирдол нь цөлжилт нэмэгдэх зэргээр байгаль орчин, ургамлын бүрхэвчид ноцтой сөрөг үр дагавар бий болгох эрсдэлтэй.

5.3 Гүйцэтгэлийн Шаардлага 5: Газар чөлөөлөх, албадан нүүлгэн шилжүүлэлт ба эдийн

⁸⁷ ЭХ СУРВАЛЖ ЗААГААГҮЙ БАЙНА

Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл – Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

засгийн суурьшил алдалт

Газар чөлөөлөх, тухайн газар ашиглахыг хязгаарласны улмаас албадан нүүлгэн шилжүүлэлтэд өртөх сөрөг нөлөөллийг бууруулахад Гүйцэтгэлийн Шаардлага 5-ын зорилго оршдог. Тухайлбал, төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор амьдралын хэв маяг алдагдах, эсвэл бохирдол үүссэнээс болж малын тоо толгой олноор хорогдох зэрэг нь нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой нөлөөлөлд тооцогдоно. Албадан нүүлгэн шилжүүлэлтийг дор

дурдсан хоёр тохиолдлын аль алиныг нь хамарсан байдлаар тодорхойлдог, тухайлбал:

- Малын өвөлжөө, хашаа зэргийг нүүлгэн шилжүүлэх, эсвэл эдгээрийг алдах биет нүүлгэн шилжүүлэлт; ба эдийн засгийн суурьшил алдалт, өөрөөр хэлбэл, хөрөнгөө алдсанаас болж орлогын буюу амьжиргааны эх үүсвэрээ алдах. Ингэхдээ 'суурьшил алдалт' нь хууль эрхзүйн хувьд баталгаажсан газар эзэмших эрхтэй (буюу газар эзэмших бичигтэй), эсвэл газар эзэмших нэхэмжлэл гаргах эрхтэй иргэд, мөн заншлын хуулийн дагуу газар эзэмших эсвэл эзэмших нэхэмжлэл гаргах эрхтэй иргэд, эзэмших эрхгүй ч гэсэн газар ашигладаг иргэд, мөн малчид шиг улирлын байдлаар байгалийн нөөц ашигладаг иргэдийн аль алинд нь ижил хамаарна.

Энэхүү ГШ 5-ыг хангахын тулд “Алтайн Хүдэр” компани нөлөөлөлд өртсөн иргэд (тэр дундаа нүүн очих газрын ард иргэд)-тэй зөвлөлдөх, эдийн засгийн суурьшил алдалт, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотойгоор шийдвэр гаргахад мэдээлэл дээр үндэслэсэн оролцоог хангах зэрэг арга хэмжээг авсан байх шаардлагатай. Нөлөөлөлд өртсөн иргэд нөхөн олговрыг олгох хэлбэрүүд, нүүн шилжихэд олгох тусламж, нүүлгэн шилжүүлэхээр санал болгосон газар хүн, мал амьдрахад тохирч байгаа эсэх талаар хэлэлцээ хийхэд оролцох бололцоогоор хангагдсан байх ёстой. Өвөлжөөний газар эзэмших эрхгүй малчдын хувьд “Алтайн Хүдэр” компани эзэмших эрх нь баталгаажсан, хүн мал идээшихэд тохиромжтой өөр газар санал болгох ёстой байсан. “Алтайн Хүдэр” нь нүүлгэн шилжүүлсэн малчид, мөн нүүн очсон газар амьдарч байгаа бусад малчдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мониторингийн хяналт тавих, үнэлгээ хийх зорилгоор Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, мөн эдийн засгийн суурьшил алдалтд өртсөн малчдын Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр боловсруулсан байх ёстой байсан.

Нөхөн олговрын төрлийн хувьд өрхийн амьжиргаа газраас хамааралгүй, эсвэл төслийн хэрэгцээнд авсан газар иргэдийн нийт газрын багахан хэсгийг эзэлж байгаа, мөн үлдсэн газар нь эдийн засгийн хувьд ашигтай буюу зөвхөн эдгээр тохиолдолд нөхөн олговрыг бэлэн мөнгөөр олгож болно гэж ГШ 5-д тусгайлан заасан байдаг.⁸⁸ Харин өрхийн амьжиргаа газраас хамааралтай бол нөхөн олговор мөн адил газар дээр суурилсан байх шаардлагатай байдаг.⁸⁹

Өмнөх бүлэгт өгүүлсэнчлэн, компани хүн малд тохиромжтой нүүлгэн шилжүүлэх газрыг малчдад санал болгоогүйгээс гадна хэрхэн нүүлгэн шилжүүлэх гэж байгаа талаар малчдад ямар ч мэдээлэл өгөөгүй байна. Газар дээр суурилсан байх ёстой нөхөн олговрын оронд нүүлгэн шилжүүлсэн малчид гар дээрээ бэлэн мөнгө авсан ба энэхүү нөхөн олговрын төрөл нь Монголд, бэлчээрийн газрыг худалдах, худалдах авах эрхзүйн тогтолцоо байдаггүй нөхцөлд газар дээр суурилсан амьжиргааг нөхөх зохистой хэлбэр болж чадахгүй. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, мөн Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр байдаг эсэх талаар ямар ч мэдээлэл байхгүй байна.

⁸⁸ ЕСБХБ, Байгаль орчин, нийгмийн бодлого, 2014 оны 5-р сар, < <http://www.ebrd.com/downloads/research/policies/esp-english.pdf>> (2014 оны 10-р сарын 21), 35 ба 26 дахь хэсэг, хуудас 33-34.

⁸⁹ Мөн тэнд, хуудас 33.

5.4 Гүйцэтгэлийн Шаардлага 10: Мэдээллийн ил тод байдал ба сонирхогч талуудын оролцоо

Орон нутгийн иргэдэд үзүүлэх байгаль орчин, нийгмийн нөлөөллийг үр дүнтэйгээр удирдахын тулд мэдээллийн ил тод байдал, сонирхогч талуудын оролцоог хангахын ач холбогдлын тухай Гүйцэтгэлийн Шаардлага 10-т онцлон заасан байдаг. Сонирхогч талуудын оролцоог хангах гэдэгт мэдээллийн ил тод байдлыг хангах, нөлөөлөлд өртсөн талуудтай зөвлөлдөх, мөн тэдгээрийн өргөдөл гомдлыг барагдуулах механизм бүрдүүлэхийг ойлгодог.

Энэхүү Гүйцэтгэлийн Шаардлагыг хангахын тулд “Алтайн Хүдэр” компани уурхайн төсөл болон Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар мэдээлэл өгөх, мөн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар сонирхогч талуудын санал хүсэлтийг нь авч байх ёстой. Өмнөх бүлэгт өгүүлсэн зүйл, мөн бусад Гүйцэтгэлийн Шаардлагуудын хэрэгжилтэд хийсэн дээрх үнэлгээнээс үзэхэд компани эдгээр ГШ-уудыг хэд хэдэн байдлаар зөрчиж байна. Ярилцлагад хамрагдсан бүх хүмүүс компани, түүний хөрөнгө оруулагчид, мөн уурхайн төслийн талаар ямар ч мэдээлэлгүй гэдгийг онцлон тэмдэглэж байсан. Уурхай, мөн уурхайг дагасан дэд бүтэцтэй холбоотойгоор үүсэх магадлалтай, мөн үүсч байгаа бодит нөлөөллийн талаар ярилцлагад хамрагдсан иргэд огт ойлголтгүй байснаас гадна тулгамдаж байгаа асуудлаар компанитай зөвлөлдөх бололцоогоор огт хангагдаж байгаагүй байна. Үүнээс гадна сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулах, талуудын янз бүрийн ашиг сонирхлыг хангасан, аль аль талд хүлээн зөвшөөрөгдөх арга замыг эрэлхийлэх талаар зөвлөлдөх арга хэмжээг компанийн зүгээс огт авч байгаагүй байна. Үнэн хэрэгтээ уурхайн төслийн талаар гомдлоо илэрхийлсэн долоон иргэний эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Гомдол барагдуулах үр дүнтэй механизмыг бүрдүүлээгүй, ингэснээр өргөдөл гомдол хүлээн авах, тэдгээрийг аливаа шийтгэл ногдуулах, дарамт шахалт үзүүлэхгүйгээр шуурхай барагдуулах арга хэмжээ авч байх процессыг бүрдүүлэх шаардлагыг компани зөрчсөн байна. Гүйцэтгэлийн Шаардлагуудыг хэрэгжүүлэх тухай ЕСБХБ-ны удирдамжийн дагуу хөндлөнгийн, давж заалдах шударга механизмыг бүрдүүлсэн байх шаардлагатай. Өмнөх бүлэгт дурдсанчлан, компани Цээл сумын төвд өргөдөл гомдол хүлээн авах хайрцаг байрлуулсан, гэтэл ярилцлагад хамрагдсан нэг л малчин ийм хайрцаг байдгийг мэдэж байсан төдийгүй компани уг малчны гомдлын мөрөөр ямар ч арга хэмжээ аваагүй байна.

6. Дүгнэлт

Өмнөх бүлгүүдэд тодорхой дурдсан зүйлүүд дээр үндэслэн төмрийн хүдрийн салбарт бүхэлд нь хамаарах хэд хэдэн дүгнэлт хийх боломжтой байна. Энэ бүлэгт хэд хэдэн үр дүнгийн талаар өгүүлэхийн зэрэгцээ дараахь дүгнэлтийг хийсэн, үүнд:

- Уурхайн дэд бүтэц болох тээвэрлэлтийн замтай холбоотойгоор орон нутгийн иргэд сөрөг нөлөөлөлд өртөх нь их байна;
- Ганц удаагийн бэлэн мөнгөний нөхөн олговор нь үр дүнгүй, сөрөг үр дагавартай нөхөн олговрын хэлбэр болж байна;
- Уурхайн богинохон насжилт, үйлдвэрлэлийн өндөр төлөвлөгөө нь сонирхогч талуудын оролцоог жинхэнэ утгаар нь бүрдүүлэх аливаа эрмэлзлэлийг үгүй болгож байна.

6.1 Тээвэрлэлтийн зам орон нутгийн иргэдэд сөргөөр нөлөөлж байна

Энэхүү кейс судалгаа нь сонирхогч талууд уурхайн олборлолтоос гадна уурхайг дагасан дэд бүтэцтэй холбоотойгоор мөн адил сөрөг нөлөөлөлд өртөж болдгийг харуулж байна. Энэ нь төмрийн хүдрийн үйлдвэрлэлд бүр ч их хамаатай байдаг, учир нь ямар ч төмрийн хүдрийн компанийн бизнесийн загварт тээвэрлэлтийн асуудал хамгийн чухал хүчин зүйл нь болж байдаг, иймээс зам, эсвэл төмөр зам төмрийн хүдрийн компанийн бизнесийн салшгүй хэсэг нь болж байдаг.

“Алтайн Хүдэр” компанийн хувьд уурхайгаас Хятадын хил хүртэл хатуу хучилттай зам тавьснаар тээвэрлэлтийн зардлаа бууруулах давуу талыг компанид бий болгож байгаа юм. Гэвч одоо ашиглаж байгаа шороон зам, мөн шинэ зам тавих барилгын ажилтай холбоотойгоор зам дагуу амьдардаг нүүдэлчин малчин өрхүүдэд сөрөг нөлөөлөл үүсч байна. Малчдын хэлж байгаагаар төмрийн хүдэр тээвэрлэдэг хүнд даацын машинаас үүсэх тоосжилт, шинэ зам барихад шаардлагатай хайрга олборлох карьерууд нь бэлчээрээс гадна малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Гарц гарамгүй баригдаж байгаа замын өндөрлөг хэсгийг мал амьтан хөндлөн гарахад хүндрэл гарч байгаа, үүнээс болж мал замын цаад талд гарч бэлчиж чадахаа байх, өвөлжөө хаваржаа руу нүүхэд хүндрэл гарах зэрэг сөрөг нөлөөлөл байгаагийн сацуу хайрга олборлох карьерууд малын үржил шимтэй бэлчээрийн газрыг доройтуулж улмаар малын эрүүл мэндэд хохирол үзүүлж байна.

Судалгааны эдгээр үр дүнгээс үзэхэд уурхайн олборлолтоос сөрөг нөлөөлөлд өртсөн малчдын бүлэг уурхайн талбар газар, эсвэл уурхайн ойр орчим амьдарч байгаа малчдаас хамаагүй том байна. Дэд бүтцийг хөгжүүлэх нь уурхайн ойр хавийн иргэдэд эерэгээр нөлөөлдөг хэмээн олонтаа ярьж ойлгуулдаг, ихэнх тохиолдолд ийм ч байдаг. Гэсэн хэдийч шинээр тавигдсан зам малчдын ашиглаж байгаа бэлчээрийг хуваах, уурхайн олборлолтой шууд холбоотойгоор нэмэгдэх тээвэрлэлтийн улмаас зам дагуу амьдардаг иргэдээс гадна уурхайн сайтаас хол амьдардаг иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд мөн адил ихээхэн сөрөг нөлөөлөл бий болж байна.

Тээвэрлэлтийн зардал төмрийн хүдрийн үнэ бүрдүүлдэг чухал хүчин зүйл болж байдгаас Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл – Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

гадна төмрийн хүдрийн компаниудын өрсөлдөх чадварыг тодорхойлж байдаг. Төмрийн хүдрийн шинэ уурхайнууд илүү алслагдсан орон нутагт байрлах нь олонтаа тохиолддог, учир нь экспортын хилийн боомтуудад ойр байрладаг ордыг ашиглаж дууссан байх магадлал өндөр бөгөөд үүнтэй холбоотойгоор тээвэрлэлт хийх зам урт байх магадлалтай. Иймд зам, төмөр зам зэрэг уурхайг дагасан бусад тээвэрлэлтийн дэд бүтэцтэй холбоотойгоор гарч болох байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг хүлээн зөвшөөрч байх шаардлага урган гарч байна. Иймд сайжирсан дэд бүтэц орон нутгийн иргэдэд зөвхөн эерэг үр дагавар авчирна гэж бодож ярих нь буруу, учир дутагдалтай юм гэдрийг энэхүү кейс судалгаа нотолж байна. Эдгээр иргэдийн амьжиргаа, эрүүл мэндэд мөн адил сөрөг нөлөөлөл бий болж байна.

6.2 Ганц удаагийн бэлэн мөнгөний нөхөн олговор нь нөхөн олговрын зохистой хэлбэр болж чадахгүй байна

Уг кейс судалгаанаас өөр нэг сургамж гарч байна, тухайлбал, нүүлгэн шилжүүлсэн орон нутгийн иргэдэд олгох нөхөн олговрын зохистой хэлбэр тухайн газар, орон нутгийн онцлогоос хамаарна. Хэдийгээр өмнөх нийгмээс зах зээлийн нийгэмд шилжсэн тэр үеэс хойш Монголд газрын харилцаа хувь хүнд газар эзэмших эрх олгох чиглэлээр хөгжиж ирсэн боловч ихэнх газар нутагт бэлчээрийн газар нийтийн эзэмшилд байж нийтээр ашиглагдсан хэвээр байна. Монголын малчдын хувьд, бэлчээрийг нүүдэллэн ашиглах уламжлалт хэлбэр, стратеги нь байгалийн хатуу хүнд нөхцөлд хамгийн сайн таарсан арга бөгөөд ийм ч учраас энэ хүнд хэцүү нөхцөлийг даван туулахад гол үүрэг гүйцэтгэдэг.⁹⁰ “Алтайн Хүдэр” компанийн зүгээс өвөлжөөний газраа алдсан малчдад нөхөн олговор болгож бэлэн мөнгө олгож байгаа арга хэлбэр нь үр дүнгүйгээс гадна малчдад сөрөг үр дагавар бий болгож байгааг судалгаагаар тогтоосон. Бэлчээрийн газрыг багийн иргэдийн нийтийн хурлаар хуваарилдаг тул эдгээр малчид нүүж очих өвөлжөөний газар худалдан авахад нөхөн олговроо ашиглаж чадахгүй байна. Компаниас нөхөн олговор болгож бэлэн мөнгө авсан гэсэн үндэслэлээр дор хаяж нэг малчин эмэгтэйд өвөлжөөний газар хуваарилахаас татгалзсан тухай энэхүү кейс судалгаагаар олж тогтоосон.

Бэлэн мөнгөний нөхөн олговор нь албадан нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн суурьшил алдалтд өртсөн орон нутгийн иргэдэд бий болсон эдийн засгийн болоод нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулж чадахгүй, харин ч эсрэгээр эмзэг бүлгүүдэд улам их хүндрэл учруулж болохыг дээрх жишээ харуулж байна. Өрхийн орлого сэргээгдээгүй, эсвэл нэмэгдээгүйгээс гадна нүүлгэн шилжүүлсэн малчид өрхийн амьжиргаагаа хэвийн залгуулахад улам их хүндрэл бэрхшээлтэй тулгарах болсон байна. Үүнээс гадна компани, баг болон сумын засаг захиргаа зөв, зохистой нүүлгэн шилжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх хариуцлага хүлээхээс татгалзсан, учир нь уг бүс нутагт уурхайн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хэрхэн яаж зохицуулах тухай туршлага, мэдлэг байхгүйтэй холбоотой байж болох юм. Үүнээс улбаатайгаар нүүлгэн шилжүүлсэн малчдад бага сонголт эсвэл огт ямар ч сонголт байхгүй байна.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлагууд зэрэг байгаль орчин, нийгмийн стандартууд нь амьжиргаа болон амьдралын стандартыг нүүлгэн шилжүүлсэн өмнөх түвшинд хүртэл нөхөн сэргээхэд тусалцаа үзүүлэх, компанийн зүгээс хүн мал идээших боломжтой нүүлгэн шилжүүлэх шинэ газрыг санал болгох, иргэдийн амьжиргааны эх үүсвэр газраас хамаардаг

⁹⁰ Фернандез-Гименез, М., Монгол дахь газар ашиглалт ба газар эзэмшил: товч түүх болон өнөөгийн асуудлууд. АНУ-ын ХААЯ-ны Ойн алба, 2006 он, хуудас 1, < http://www.fs.fed.us/rm/pubs/rmrs_p039/rmrs_p039_030_036.pdf > (2014 оны 11-р сарын 30).

тохиолдолд мөнгөн бус хэлбэрээр олгох нөхөн олговор зэргийг тусгасан нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан байхыг шаарддаг боловч эдгээр стандартыг тэр бүр дагаж мөрдөхгүй байна. “Алтайн Хүдэр” компанийн хувьд, Байгаль орчин, нийгмийн үнэлэлт дүгнэлт ба Үйл ажиллагааны төлөвлөгөөндөө өрхийн амьжиргааг дэмжих хэрэгцээ шаардлага, тусламжийг тодорхойлох зорилгоор нүүлгэн шилжүүлэлтийн дараахь үеийн амьжиргааны судалгаа хийх үүргийг компани хүлээсэн боловч үнэн хэрэгтээ уг үүргээ огт биелүүлээгүй. ЕСБХБ хэдийгээр компанид хөрөнгө оруулалт хийж зээл олгосон боловч өөрийн бодлогод нийцсэн үйл ажиллагаа явуулах шаардлагыг компанид тавьж ажиллаж чадаагүй.

Төмрийн хүдрийн савалгаатай болон өнөөгийн хямд үнэтэй холбоотойгоор “Алтайн Хүдэр” компани авсан зээлээ эргэн төлөхийн тулд орлогоо нэмэх шаардлагатай тулгарч байна. “Алтайн Хүдэр” компани үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд уурхайн олборлолтын талбайгаа тэлэх хэрэгтэй болно, үүнээс улбаатайгаар ирээдүйд нэмж газар чөлөөлж малчдыг нүүлгэн шилжүүлэх магадлал өндөр байна. Төмрийн хүдрийн үнэ одоогоор унасан байгаа тул үнэ буцаж өсөх үед уурхайг яаруу сандруу байдлаар тэлэх магадлал мөн адил өндөр байна. Энэ нь малчдыг бэлэн мөнгөөр ‘худалдан авах’ эрсдэлийг нэмэгдүүлж байгаагийн зэрэгцээ амьдралын түвшингээ буцааж сэргээх эсвэл сайжруулахад шаардлагатай тусламжийг малчид авч чадахгүй байх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Ирээдүйд хэрэгжүүлэх нүүлгэн шилжүүлэлт нь холбогдох байгаль орчин, нийгмийн стандартад нийцээгүй, сайтар бодож төлөвлөөгүй байдлаар хийгдэх өндөр эрсдэл байна.

Төмрийн хүдрийн хэт савалгаатай үнэ ханш орон нутгийн иргэдийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж байдгийг энэхүү кейс судалгаа харуулж байна. Төмрийн хүдрийн үнэ өндөр байна гэсэн баталгаа байхгүй тул компаниуд үнэ өндөр байгаа богинохон хугацаанд амжин үйлдвэрлэлийнхээ хэмжээг эрс нэмэгдүүлэх бүхий л бололцоог ашиглахыг эрмэлзэнэ. Төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн хэмжээг огцом нэмэгдүүлснээр нүүлгэн шилжүүлэлтийг сайтар төлөвлөж хэрэгжүүлэх боломж төдийлөн гарахгүй ба улмаар нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд үүсэх сөрөг нөлөөлөл улам ихсэх эрсдэлтэй.

6.3 Уурхайн богино насжилт сонирхогч талуудын бодит оролцоог хангах хөшүүрэг болж чадахгүй байна

Гуравт, “Алтайн Хүдэр” компани сонирхогч талуудын оролцоог бодит байдлаар хангахгүй байна. Нэг талаар компани зөвхөн цаасан дээр л хийсэн гэж тэмдэглэх байдлаар энэ асуудалд хандаж байна. Санал хүсэлт авах хайрцаг байрлуулснаа өргөдөл гомдол барагдуулах механизм бүрдүүлсэн хэмээн компанийн зүгээс үзэж байгаа бололтой. Гэвч энэхүү механизм үр дүнтэй ажиллаж чадахгүй байна, учир нь ярилцлагад хамрагдсан малчдын ихэнх нь санал хүсэлтийн хайрцаг байдаг тухай мэдэхгүй байна. Дээр дурдсанчлан, нэг малчин өөрийн санал гомдлоо бичиж энэ хайрцагт хийсэн боловч компаниас түүний гомдлын дагуу огт хандаж байгаагүй байна.

Нөгөөтэйгүүр, компанийн үйл ажиллагаанд шүүмжлэлттэй хандсан иргэдэд компанийн зүгээс хэт хэрцгий байдлаар хандаж байна. Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөлөлд шүүмжлэлтэй хандсан малчид, иргэдийн хурлын зарим төлөөлөгчид, мөн бусад сонирхогч талуудын эсрэг компани гомдол гаргаж *‘зохион байгуулалттайгаар бусдын нэр хүндэд халдаж, гутаан доромжлох’* гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэж шүүхэд хариуцагчаар дуудуулж байсан. Анхан шатны шүүхээс уг хэргийг хэрэгсэхгүй болгосон хэдийч компани шүүхийн шийдвэрийг эсэргүүцэн давж заалдсан ба хяналтын шатны шүүх

иргэдийн талд эцсийн шийдвэр гаргасан. Гэвч хэрэг шүүхээр шийдэгдэх хугацаанд иргэд нийслэл хот орох зэрэг ихээхэн хэмжээний зардал гаргасан ба компанийн энэхүү үйлдэл нь тэдгээрийг айлган сүрдүүлэх, дуугуй байлгах оролдлого хэмээн шүүхэд татагдаж байсан иргэд үзэж байна.

Орон нутгийн иргэдтэй хандаж байгаа компанийн энэхүү хандлагыг уурхайн харьцангуй богино насжилттай холбож тайлбарлаж болох юм. Төмрийн хүдрийн нөөцийг 10 жил хүрэхгүй хугацаанд олборлож дуусах тооцоо байгаа ба уурхайн олборлолтын ийм богино хугацаа нь сайн хөрш болж ажиллах хөшүүргийг бий болгохгүй байна. Харин ч компанийн бизнесийн загвар нь үйлдвэрлэлийн хэмжээг жил бүр өсөн нэмэгдүүлэх стратегид суурилсан байна, иймд орон нутгийн иргэдийн оролцоог жинхэнэ утгаар нь хангах гэвэл цаг хугацаа авах тул компанийн бизнесийн стратегитэй зөрчилдөхөөр байна. Компани уурхайн олборлолтоо дуусгаж уурхайн талбайгаа орхиж гарахаас хэдхэн жилийн өмнөөс компанийн үйл ажиллагааны талаарх шүүмжлэлийг тодорхой хэмжээнд саармагжуулж болох юм.

6.4 ЕСБХБ-ны оролцоо сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх баталгаа болж чадахгүй байна

Эцэст нь, хөгжлийн банк уурхайн төсөлд хөрөнгө оруулалт хийж оролцож байгаа нь энэхүү кейс судалгааны нэг онцлог болж байна. ЕСБХБ-наас “Алтайн Хүдэр” компанид оруулсан хөрөнгө оруулалт нь Төв болон Зүүн Европ, Төв Азийн болон Газрын дундад тэнгисийн орнуудын зах зээлийн эдийн засагт шилших шилжилтийг дэмжих үүднээс эдгээр орнууд дахь уул уурхайн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх стратегийн нэг хэсэг нь ажээ. ЕСБХБ-ны Уул уурхайн салбарт баримтлах бодлогод дурдсанчлан, энэхүү стратеги нь төрийн оролцоо; худалдааны саад тотгор; дэд бүтэц хөгжөөгүй байдал; хуучирсан технологи зэрэг ‘шилжилтийн сорилтуудыг’ даван туулах, мөн хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, олон улсын шилдэг практик, тэргүүн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэж байна.⁹¹

ЕСБХБ болон бусад хөгжлийн банкуудын хөрөнгө оруулалтын стратегид нийгэм, байгаль орчны асуудлууд чухал байр суурь эзэлж байдаг тул эдгээр банкууд бусад хөрөнгө оруулагчдаас ялгарч байдаг юм. ЕСБХБ хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч байдаг тул Таян нуурын төсөлд ЕСБХБ-наас хөрөнгө оруулалт хийснээр уурхайн нийгэм, байгаль орчны менежментийг сайжруулах, малчид, орон нутгийн сонирхогч талуудад учирч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой хэмээн үзэж болох юм. Гэвч ЕСБХБ-ны оролцоо орон нутгийн сонирхогч талуудад үүсч байгаа нийгэм, байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж чадахгүй байгааг энэхүү кейс судалгаа харуулж байна.

Энэ нь үр дүн муутай нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээ авах, эсвэл сонирхогч талуудын оролцоог хангаж чадаагүй тохиолдолд ЕСБХБ-ны зүгээс зохих хариуцлага тооцох механизм байдаггүйтэй холбоотой байж болох юм. Компани банкны Гүйцэтгэлийн Шаардлагуудыг хэд хэдэн чиглэлээр хангаагүй байна гэдгийг 2011 онд хийсэн үнэлгээгээр тогтоож байсан бол гурван жилийн дараа компани нэг бус Гүйцэтгэлийн Шаардлагыг ханган ажиллаж чадахгүй байсаар байгааг энэхүү кейс судалгаагаар харуулсан болно. Тодруулбал, нүүлгэн шилжүүлэлтийн дараа малчдын амьжиргаанд гарсан өөрчлөлтийн талаар хийсэн судалгаанд малчид, бусад сонирхогч талуудыг хамруулаагүй, тэр ч бүү хэл малчид ийм судалгааны

⁹¹ ЕСБХБ, Уул уурхайн салбарт баримтлах бодлого, 2012 оны 10-р сарын 17-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас батлагдсан. <http://www.ebrd.com/downloads/policies/sector/mining-operations-policy.pdf> (2014 оны 10-р сарын 21).

талаар огт сонсож байгаагүй байтал компанитай ямар ч хариуцлага тооцох, эсвэл нөлөөлөх ямар ч арга хэмжээ аваагүй байна.

Орон нутгийн иргэд, малчдын эрхийн асуудлаар сонирхогч талуудтай жинхэнэ утгаар нь зөвлөлдөж тэдгээрийн оролцоог хангах, нийгэм, байгаль орчны сөрөг нөлөөллийг нийтэд өгөөжтэй байдлаар бууруулах зохистой арга хэмжээнүүд нь компанийн удирдлагуудын сайн санаа, санаачлага эсвэл компанийн хөрөнгө оруулагчийн тогтвортой хөгжлийн бодлогоос зөвхөн хамаардаггүй гэдгийг энэхүү кейс судалгаа харууллаа. Эдгээр нь дэд бүтэц хөгжүүлэх, уурхайн ашиглалтын хугацаа, үйлдвэрлэлийн зорилт зэрэг бизнесийн хүчин зүйлсээс мөн адил хамаарч байна. Эдгээр бизнесийн хүчин зүйлс нь талуудын оролцоог хангах, малчдыг нүүлгэн шилжүүлэх үйл явцтай зөрчилдөх тохиолдолд малчид, орон нутгийн иргэд, бусад сонирхогч талуудын эрх зөрчигдөх, тэдгээрийн амьжиргаа доройтох эрсдлийг бий болж байна.

Хавсралт: ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлагууд

Доор хүснэгтэд ЕСБХБ-ны 10 Гүйцэтгэлийн Шаардлага (ГШ) тус бүрийг танилцуулсан холбоосыг оруулав.⁹²

ГШ 1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ ба менежмент

ГШ 2: Хөдөлмөр ба ажиллах нөхцөл

ГШ 3: Бохирдлоос урьдчилан сэргийлэх ба багасгах

ГШ 4: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал

ГШ 5: Газар чөлөөлөх, албадан нүүлгэх ба эдийн засгийн суурьшил алдалт

ГШ 6: Биологийн олон янз байдлыг хадгалах ба амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент

ГШ 7: Нутгийн уугуул иргэд

ГШ 8: Соёлын өв

ГШ 9: Санхүүгийн зуучлагч байгууллагууд

ГШ 10: Мэдээллийг ил тод болгох ба Сонирхогч талуудын оролцоо

⁹² ЕСБХБ-ны веб хуудас, “ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлагууд”, огноогүй, < <http://www.ebrd.com/environment/e-manual/e31ebd-performance-requirements.html>> (2014 оны 10-р сарын 21).

Дэлхийн төмрийн хүдрийн салбарын нөлөөлөл

Кейс судалгаа: Монголын “Алтайн Хүдэр” ХХК

Aspiet invende llander umquatio doluptas sitatio nседis eossus. Pedi rehenihici con conseruptur apernati nus nobisquas ab ius a dolum quam quat volorepudi susdae voloribea ditis del illaccu lluptatiis audandundis que dellandus ilisquist por a nullupt aturepro ex est alibus. Facillu ptibus eaquibus aut omnimagnat. Et et aut ventia dolore volorem corum ipsanihit fuga. Ercilite poriti cus et dolut vent omnisit ereicilis etur modit essint, cum elescia sae cus, sequi unt mo et facepta simperem illentur sunt antem velestia viduciu ndipsae ruptatumque ipsae eate elibus consedion reium laccae. Et aut ventia dolore volorem corum ipsanihit fuga.

